

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2009-2012 ОНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

2009 он

Баянхонгор

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт			
Хяналтад авсан нийт тоо		182	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			
Үүнээс	Биелсэн /100%/		8
	Хэрэгжих шатандаа		174
	Үүний дотор	90%	3
		70%	10
		50%	7
		30%	133
		10%	14
	Тасарсан		8
	2009 оны хэрэгжилтийн хувь		136%
	Дүн:		
4 жилийн хэрэгжилтийн дундаж хувь:		34,17%	

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

Боловсрол, шинжлэх ухааны бодлого	
Иргэдийн сурч боловсрох, хөгжих, бүтээлч хандлагыг дээшлүүлж боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	
1.1.1. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдад сурах адил тэгш боломж олгож, тэдний нийгэмшил, төлөвшилд төр, эцэг, эх, олон нийтийн оролцоо хамтын ажиллагааг идэвхижүүлнэ.	<p>ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 230 багшийг анги дэвших хүүхдүүдэд хичээл заах арга зүйг эзэмшүүлэх сургалтад, эцэг эх болон иргэдийн нийгмийн сэтгэл зүйг бэлтгэх зорилгоор 8 удаагийн сургалт сурталчилгааны ажилд 6850 хүн хамруулж, 53000 эцэг эхэд мэдээлэл хүргэж сурагчдыг ном, сурах бичгүүдээр бүрэн хангасан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
1.1.2. Боловсролын салбарын хүний нөөцийн хуваарилалтыг оновчтой байршуулан, мэргэжилтэй боловсон хүчнээр ханган, мэргэжил дээшлүүлэх, сургах менежментийг сайжруулна.	<p>Шилжилтийн 7 дугаар ангийн сургалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтад 230 гаруй багш, “Суралцагчийн суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” сургалтад 36 багш, сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд туслалцаа хүссэн 7 сургуулийн 194 багшид нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалт, МХТ-ийг сургалтанд 180 гаруй багш, Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх нь” вакумжуулсан сургалтанд 28 багш, зуны сургалтанд 30 багш, нийт 600 гаруй багш төвлөрсөн болон орон нутгийн сургалтанд хамрагдаж ажлын байран дээрээ мэргэжил боловсролоо дээшлүүлсэн. Мэргэжлийн багшийн хангалт аймгийн төвд 99,75 хувь, хөдөө орон нутагт 96,1 хувь, нийтдээ 98 хувь, цэцэрлэгийн багшийн хангалт аймгийн төвд 96 хувь, хөдөө сумдад 83,6 бүгд 89,2 хувьтай байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
1.1.3. Хүүхэд, залуучуудад амьдралын зөв дадал олгох, аливаа хорт зуршлаас ангид байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил төлөвшүүлэх ёс суртахуунтай иргэн	<p>“Хүүхэд залуучуудын хөгжил төлөвшилд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх цогц үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхлээд байна.</p>

болгох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	
	<b>/Хэрэгжилт-30%/</b>
1.1.4 СӨБ, ЕБС-ийн хамран сургалтыг нэмэгдүүлж, сургалтын орчныг сайжруулан, ээлжийн коэффициентийг бууруулна.	2009-2010 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 98.0 хувь, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 99 хувь, сургууль завсардалт 0.15 хувьтай байна. Хамран сургалт 99 хувьтай байна.Аймгийн төвд 4-р 10 жилийн сургуулийг ашиглалтад оруулснаар 3 –р ээлж хичээллэхгүй болж ээлжийн коэффициент буурлаа.
	<b>/Хэрэгжилт-30%/</b>
1.1.5 Англи хэлийг бүх нийтийн хүртээл болгож үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад Англи хэлний боловсрол олгох, тэдний англи хэлний боловсролыг дээшлүүлэх зорилгоор Номгон, Эрдэнэмандал, Номундалай сургуулиудын англи хэлний багш нартай хамтран Төрийн албан хаагчдын дунд зарласан “Англи хэл сурцгаая” аяны хүрээнд 3000 гаруй төрийн албан хаагчдын 15 хувь буюу 500 албан хаагч анхан шатны сургалтанд хамрагдсан.
	<b>/Хэрэгжилт-30%/</b>
1.1.6. Аймгийн хүн амын боловсрол, мэргэжлийн өнөөгийн байдалд нарийвчилсан судалгаа хийж статистик судалгаа, тоо баримтад тулгуурлан нэн хэрэгцээтэй боловсон хүчнийг шинээр бэлтгэх, давтан сургахад холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж хэрэгжүүлнэ.	Аймгийн МСҮТ-д зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалтын бүтцийг олон хувилбартай уян хатан болгож 1, 2,-2,5 жилийн ангиудад мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор шинээр <b>587</b> суралцагч элссэний <b>287</b> нь суурь боловсрол эзэмшигч байгаа нь нийт шинээр элссэн суралцагчдын <b>49</b> хувийг эзлэж байна. Энэ нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад <b>/646 элсэгчээс 628 буюу 97 хувь нь суурь боловсрол эзэмшигчид байсан/</b> суурь боловсрол эзэмшигчдийн элсэлтийг <b>48</b> хувиар бууруулж бүрэн дунд боловсролтой элсэгчдийн хувь өссөн нь мастер төлөвлөгөөний заалтыг хангаж байна.
	<b>/Хэрэгжилт- 30 хувь/</b>
1.1.7. Албан бус боловсролын үр нөлөөг	18-35 насны залуучуудын бичиг үсгийн боловсролын статистик мэдээг

<p>дээшлүүлж, гэгээрлийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бичиг үсэг үл мэдэгчгүй болох, амьдрах ухааны чадамжийг сайжруулна.</p>	<p>шинэчилж бичиг үсэг үл мэдэгчдийн судалгааг сум, багаар 2 удаа нарийвчлан гаргахад 875 залуучууд бичиг үсэг үл мэдэгч байгаагийн 60 хувийг бичиг үсэгтэн болгон зорилт тавьж 525 иргэнийг бичиг үсэг тайлагдах сургалтад хамрууллаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.1.8. Аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх ажлыг оновчтой төлөвлөн “Мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан, мэргэжилтэй ажилчдын нөөцийг бүрдүүлэх аймгийн дэд хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан мэргэжилтэй боловсон хүчинг төлөвлөх хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж МСҮТ, ХХҮХэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-50%/</p>
<p>1.1.9. Их дээд сургуулиудыг түшиглэн хүний хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн судалгаа шинжилгээний баг байгуулан үйл ажиллагааг нь бодлогоор дэмжинэ.</p>	<p>Аймагт байгаа дээд сургуулиудад судалгааны баг байгуулж тус багаас 3-р сард “Орон нутгийн хөгжил ба хүнсний аюулгүй байдал” сэдвээр МСҮТ, ХонгорДС,ХҮДС-ийн оюутнуудын дунд илтгэлийн уралдааныг зохион явуулж МСҮТ, ХҮДС-ийн оюутнуудын нийт 15 илтгэл хэлэлцэгдсэнээс 1-т “Махыг малчдын гар дээрээс шууд худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх нь”, 2-т “Эрүүл хүнс ба цагаан хоолны ач тус” илтгэл 2-р байр, 3-т “ Контейнерийн худалдаа ба хүнсний аюулгүй байдал” илтгэлүүд шалгарав.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.1.10 Баянхонгор хотод 640 хүүхдийн суудалтай 11 жилийн 4-р дунд сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, Галуут сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, Баянцагаан суманд 110 хүүхдийн цэцэрлэгийн барилгын дутуу хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.</p>	<p>Баянхонгор сумын 640 хүүхдийн суудалтай 11 жилийн 4-р сургуулийн байр, Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга, “Хүүхэд-залуучуудын хөгжлийн төв”-ийг ашиглалтад оруулж,, Галуут сумын 320 хүүхдийн суудалтай сургууль –ийн барилгын гүйцэтгэл 60 %-тай хийгдээд байна.150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын үлдэгдэл хөрөнгийн асуудал одоо хүртэл шийдэгдэхгүй байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-70%/</p>
<p>1.1.11 Соого Сейко, Бууцагаан суманд 240 хүүхдийн суудалтай бага сургуулийн</p>	<p>Соого сейко сургуулийн өргөтгөлийн асуудлыг Японы элчин сайдын яамны “Өвсний үндэс” хөтөлбөрт санал тавьж 50,000, Ойта мужид санал</p>

<p>барилгын өргөтгөл, 6-р цэцэрлэгийн цэвэр бохир усны шугам, сүлжээний хөрөнгийн асуудлуудыг шийдвэрлэж ашиглалтанд оруулна.</p>	<p>тавьж 50,000 долларын хандиваар шийдвэрлэхээр хөрөнгийн асуудал шийдэгдээд байна. 6-р цэцэрлэгийг цэвэр бохир усны системд холбох зураг хийлгэсэн. Бууцагаан суманд 240 хүүхдийн бага сургууль барих зураг, төсөв хийгдсэн ч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.1.11. Эрдэнэцогт, Баянбулаг Баян-Өндөр, Богд, Өлзийт сумын сургууль, Баянхонгор сумын 1-р ясли-цэцэрлэг, 7-р цэцэрлэг, Богд, Галуут, Бууцагаан, Баацагаан сумын цэцэрлэгийн барилгын их засвар, Баянхонгор сумын 2, 3, 4-р цэцэрлэгийн сантехникийн засвар, Баацагаан сумын сургуулийн биеийн тамирын болон хоолны заалны халаалтыг их засварт оруулна.</p>	<p>Богд сумын цэцэрлэгийн засвар, Заг сумын спорт заалны засвар, Номгон ахлах сургуулийн цэвэр бохир усны татуургын засвар, 3-р цэцэрлэгийн цэвэр бохир усны холболтыг тогтвортой амжиргаа төслөөр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зэлтэй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Галуут, Номундалай, Гурванбулаг, Богд, Баянцагаан Бууцагаан, Номгон зэрэг 10 сургууль, 2-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 7-р цэцэрлэг, Гурванбулаг, Бууцагаан зэрэг 5 цэцэрлэгт орц гарц болон ариун цэврийн газрын тохижилтын ажлыг Европын Холбооны комисс, Их Британы Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр хийсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.1.12 Баянбулаг, Хүрээмарал сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын дээвэр, цонх, халаалтын их засвар, Галуут, Бөмбөгөр, Богд, Бууцагаан сумын дотуур байр, Номундалай сургуулийн II дотуур байранд их засвар оруулан хүүхдийн сурах хөгжих, амьдрах таатай орчинг бүрдүүлнэ.</p>	<p>Баянбулагийн цэцэрлэгийн дээврийг Жей Си Эс байгууллагын хөрөнгөөр, Баянбулаг, Хүрээмаралын цэцэрлэгийн цонх, хаалгыг ТАТ-өөр засварлаж, Бөмбөгөрийн дотуур байранд засвар хийж ашиглалтад оруулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 30%/</p>
<p>1.1.13. Баянхонгор суманд сургууль цэцэрлэг өргөтгөл хийх, шинээр барих болон Шинэжинст сумын сургууль, цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Гурванбулаг, Өлзийт, Баянбулаг сумын сургуулийн хичээлийн байр, Заг сумын сургууль, цэцэрлэг, Баянхонгор сумын 2, 4, 5-р цэцэрлэгийн өргөтгөлийг барих хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.</p>	<p>Баянхонгор суманд шинээр 75 хүүхдийн цэцэрлэгийн хөрөнгийн асуудлыг 2010 оны төсөвт оруулж шийдвэрлүүлсэн. Шинэжинст сумын сургууль, цэцэрлэг, Баянбулаг сумын сургуулийн спорт заалны зураг, төсөв хийгдсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.2.1. Соёл урлагийг 2009-2012 онд хөгжүүлэх</p>	<p>Аймгийн соёл, урлагийн байгууллагууд /ХДТ, Номын сан, Музей, сумдын</p>

<p>“Соёл урлаг” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Соёлын төв/ 2009-2012 онд хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Соёлын байгууллагуудын боловсруулсан хөтөлбөр, санал, аймгийн Хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг үндэслэн аймгийн Соёл, урлагийн байгууллагыг хөгжүүлэх “Соёл, урлаг” хөтөлбөр боловсруулан Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ажлын төлөвлөгөөнд тусгаад байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт- 90%/</b></p>
<p>1.2.2. Төв, хөдөөгийн соёл урлагийн байгууллагын ажилтан, мэргэжлийн уран бүтээлчдийн боловсрол, мэргэжлийг дээшлүүлж, 95-аас доошгүй хувийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, гадаадын орнуудад явуулж туршлага судлуулах, соёлын төвүүдийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд үйлчлэх хүрээг өргөтгөнө.</p>	<p>- Соёлын ажилтан, уран бүтээлчдийн ур чадвар, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах зорилгоор СУИС, СДС, БСШУЯ, ОУ-ын төсөл, хөтөлбөрийн чиглэлээр зохион байгуулсан сургалтанд 2009 онд 51 хүнийг хамрууллаа. СДС-ийг 7 хүн төгсч аймгийн ХДТ, Музей, Гурванбулаг сумын соёлын төв зэрэг газруудад ажиллаж байна. Аймгийн ХДТ-ын 5 уран бүтээлч, Номын сангийн мэдээллийн ажилтан, Жаргалант, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Баянцагаан сумын номын санч, Бууцагаан, Баянлиг, Баян-өндөр, Жинст, Баянговь сумын хөгжим, бүжгийн багш бүгд 14 хүн СДС-д эчнээгээр суралцаж байна..</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт- 30%/</b></p>
<p>1.2.3. Бүсийн төвийн сумдын соёлын төвийн материаллаг хангамж, орчин нөхцлийг сайжруулж, суурин ба явуулын үйлчилгээг нэмэгдүүлж, авто машинаар хангана.</p>	<p>БСШУЯ-наас зарласан “Соёлын төв-чанартай үйлчилгээ-2” болзолт уралдааны хүрээнд соёлын үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрээ өргөжиж, хөдөөгийн малчид, баг, бүсийн сум болон зэргэлдээх сумдад урлаг, соёлын явуулын үйлчилгээг хүргэх ажил тогтмолжиж байна. Соёлын төвүүд хөдөөд үйлчлэх график гарган иж бүрэн үйлчилгээг багт дунджаар 2-3 удаа соёлын явуулын үйлчилгээг хүргэсэн байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт -30%/</b></p>
<p>1.2.4. Баянцагаан, Бууцагаан, Баянбулаг, Гурванбулаг, Баянговь сум, Шаргалжуут тосгоны соёлын төвийн барилгыг шинээр, Баян-Өндөр сумын соёлын төвийн барилгыг гүйцээн барьж, Жаргалант, Баацагаан, Шинэжинст сумын соёлын төвийн халаалт,</p>	<p>Баянбулаг сумын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, Баянөндөр сум, Шаргалжуут тосгоны Соёлын төвийн барилгын ажил 80-90 %, Баянцагаан, Бууцагаан сумын барилгыг улсын төсвийн 460,0-600,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2010 онд барьж ашиглалтад оруулна.</p> <p>”Тогтвортой амьжиргаа-2” төслөөр Баян-Овоо сумын соёлын төвд 14,0</p>

<p>Байгалийн музейн барилга, Хүрээмарал, Шинэжинст сумын соёлын төвийн урсгал засвар, аймгийн ХДТ-ын барилгад дотор, Галуут, Баянлиг сумын соёлын төвийн их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p>сая төгрөгийн халаалт, дээврийн засвар, Баянлиг сумын соёлын төвд 10,1 сая төгрөгийн, Галуут сумын соёлын төвд 5,1 сая төгрөгийн, Баацагаан сумын соёлын төвд 16,6 сая төгрөгийн халаалт, вакум цонх, Гурванбулаг сумын соёлын төвийн номын сангийн засвар, тохижилтонд 11,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Шинэжинст сумын соёлын төвд 11,2 сая төгрөгийн халаалт, Баянцагаан сумын соёлын төвд 3,0 сая төгрөгийн цахилгаан халаалт, Бууцагаан сумын соёлын төвд Дэлхийн зөн ОУ-ын байгууллагын хөрөнгөөр 8,0 сая төгрөгийн тохижилтын ажил хийгдсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.2.5. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудад тооллого хийж, түүх, соёлын дурсгалыг аймаг, улсын хамгаалалтад авч, Эрдэнэцогт сумын Хачинламын хийдэд их засвар хийхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудад аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг тооллыг 2010 онд багтаан хийхээр аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд оруулан батлууллаа. Мөн аймаг, улсын хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалын жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудын санал, дүгнэлтийг гаргуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 10%/</p>
<p>1.2.6. Соёлын өвийн судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлж, түүх соёлын ховор үзмэр худалдан авах, үзмэр баяжуулах, чанартай үйлчилгээг хүргэх таатай орчин бүрдүүлж, улмаар аялал жуулчлалын түшиц газар болгон өргөжүүлнэ.</p>	<p>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудад аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг тооллыг 2010 онд багтаан хийхээр аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд оруулан батлууллаа. Мөн аймаг, улсын хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалын жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудын санал, дүгнэлтийг гаргуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 10%/</p>
<p>1.2.7. Номын сангийн фонд баяжилтыг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангасан орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Аймгийн Нийтийн номын сангийн 8 компьютерийг дотоод сүлжээ, интернетэд холбон, LIB4U цогц программыг суулгаж цахим номын сангийн үйлчилгээг эхэлж, 600 номыг электрон каталогт оруулж, ЕБС-ийн сургууль, цэцэрлэгийн 1018 уншигчдад 138 удаа электрон цахим үйлчилгээ үзүүлж, 42 уншигчдад Й-мейл хаяг нээн ажиллаж байна. Номын сан шинээр 525 номоор фондоо баяжуулж, шинээр баригдсан</p>

	Номын өргөөнд үйл ажиллагаагаа явуулж үйлчлүүлэгчдийн тав тухтай орчинг бүрдүүллээ. <i>/Хэрэгжилт -30%/</i>
1.2.8. Баянхонгор сумын Намдалчойнхорлин хийдэд Очирваань бурхан бүтээхэд дэмжлэг үзүүлнэ.	Сүсэгтэн олны хандив тусламж, аймгийн дэмжлэгтэйгээр Очирваань бурхныг бүтээж Намдолчойнхорлин хийдэд заллаа. <i>/Хэрэгжилт-100%/</i>
1.2.9. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн мэлмий гийсний 370 жилийн ой, бүсийн даншиг наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулна.	Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн мэлмий гийсний 370 жилийн ой, “Хангайн бүсийн их хурд-2009” даншиг наадмыг амжилттай зохион байгууллаа.Их ойн ажлын ажлын хүрээнд аймгийн хүүхдийн Тэмүүжин театр “Надтай яриач ээжээ” жүжиг, аймгийн ХДТ Г.Бирваа, Д.Намдагийн зохиол “Их хурим” хөгжимт драмын жүжиг, Ч.Бямбанямын найруулсан “Хоосон зүүд” ганц хүний драмын жүжгийг найруулан тавьж үзэгчдийн хүртээл болголоо. Аймгийн Музей Монголын Үндэсний музейд гэгээнтний эд өлгийн зүйл, зохиол бүтээлээр үзэсгэлэн гаргаж 950 гаруй төлөөлөгчдөд үзүүлж, үзэсгэлэнгийн талаар бүх хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. <i>/Хэрэгжилт-100%/</i>
1.2.10. Дэлхийд хосгүй соёлын үнэт дурсгалыг олон улсын хэмжээнд сурталчлах арга хэмжээ авна.	Одоогийн байдлаар судлах ажил хийгдэж эхлээд байна. <i>/Хэрэгжилт-10%/</i>
1.2.11.Баянхонгор хайрхан уулыг аймгийн тахилгатай уул болгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.	Аймгийн ИТХурлын 2009 оны 08 дугаар сарын 03-ний өдрийн 136 дугаар тогтоолоор Баянхонгор хайрхан уулыг “Аймгийн тахилгат”-ай уул болгох шийдвэр гаргасан. <i>/Хэрэгжилт-100%/</i>
Иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж дундаж наслалтыг уртасгана.	
1.3.1. Баянхонгор аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 15 жилийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2009-2023 онд хөгжүүлэх 15 жилийн хөтөлбөрийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 222 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. <i>/Хэрэгжилт-70%/</i>
1.3.2. Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн	“Хонгор телевиз, “All design” хэвлэлийн байгууллагатай эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны гэрээ

<p>боловсрол олгох олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>байгуулж, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох талаар 2009 онд 48 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн явуулж, олон нийтэд түгээсэн. Мөн хөдөө орон нутагт олон нийтэд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор сумдын нийгмийн эрүүл мэндийн ажилтан болон сайн дурын идэвхтнүүдэд сургалт явуулан ажлын төлөвлөгөө өгч үр дүнг тооцон ажилласан. Албан байгууллага, иргэд олон нийтэд 50 удаагийн сургалт, семинар, ярилцлага, лекц, танхимын болон зайны сургалтын хэлбэрээр 40.0 орчим мянган хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, зан үйлийг өөрчлөхөд нөлөөлж, санал асуулга авч үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнг тооцсон.</p> <p>Иргэд, хамт олны дунд 4 удаагийн тэмцээн, уралдаан зохион байгуулсан ба нийт 10136 хүн оролцсон нь урьд оноос иргэдийн оролцоо 15.3 хувиар нэмэгдсэн байна. Тухайлбал “Идэвхтэй хөдөлгөөн эрүүл аж төрөх ёс”, ахмадуудын дунд “Хөдөлгөөн эрүүл байх үндэс” “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллагын тоо урьд оноос 4-р нэмэгдэж 31 болоод байна. Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь олон нийтэд хийсэн ажлаа сурталчлах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор өөрийн тогтмол хэвлэл сонинг сар бүр гаргаж хэвшсэн.</p> <p>Дархлаажуулалтын шинэчилсэн хөтөлбөрөөр улаан бурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг вакциныг орон нутагт нэвтрүүлээд хамралт 99,1 хувьтай байна. Дархлаажуулалтын хамралтад хяналт шинжилгээ хийж хамрагдсан байдлаар нь газар нутгийн байршлыг зураг дээр өнгөөр ялган тэмдэглүүлж, хүүхдийн картан дээр хөтлүүлж байна. Мөн тууралтат халдваруудыг 7 хоногоор хянаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.3.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи, оношлогоо, эмчилгээ, телемедициний үйлчилгээг нэвтрүүлж, чанар хүртээмжийг сайжруулан түргэн шуурхай байдлыг хангана.</p>	<p>Алсын зайн оношлогооны тоног төхөөрөмжийг нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт байрлуулан, клиникийн III эмнэлэгийн оношлогооны сүлжээнд холбож, оношлогооны анхны туршилтийг хийсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>

<p>1.3.4. Хүн амыг чанарын баталгаатай эмээр хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.</p>	<p>“Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль”-ийн дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг 2009 онд 9 компани шалгаран 320 сая төгрөгний эм, биобэлдмэлээр 100% ханган нийлүүлсэн. 2010 онд 10 компани шалгарч, 393,5 сая төгрөгийн эм нийлүүлэхээр гэрээ хийгдэж, нэгдүгээр улирлын эмийн хангалтыг хийгээд байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-30%</b></p>
<p>1.3.5. Баянхонгор суманд жирэмсэн эхчүүд, бага насны хүүхдийн клиник сувилал байгуулна.</p>	<p>Баянхонгор сумын өрхийн эмнэлэгүүдтэй хамтран жин багатай хүүхэд, нэн ядуу өрхөд амьдарч байгаа жирэмсэн эхчүүдийн суурь судалгааг гаргаж 6 өрхийн эмнэлгийн тураал, сульдаа, цус багадалттай 75 хүүхдийг “Дэлхийн Зөн” БОНХХ-н 1.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр 1-р яслийг түшиглэн зуны чийрэгжүүлэх, сувиллыг ажиллуулсан. Цаашид нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийг түшиглэн хүүхдийн клиник сувилал байгуулах талаар “Дэлхийн Зөн” ОНХХ-ийн газартай ярьж тохироод байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-30%/</b></p>
<p>1.3.6. Баянхонгор, Гурванбулаг, Баацагаан сумын эмнэлгийн барилга, сумдын эмчийн орон сууцыг ашиглалтад оруулж, Баянхонгор, Баян-өндөр, Шинэжинст сумын эмнэлгийн барилгыг шинээр барих, нэгдсэн эмнэлгийн Халдварт, Хүрээмарал, Галуут, Богд сумын эмнэлгийн их засвар, Баянхонгор сумын өрхийн эмнэлгүүдийн цэвэр усны хангамжийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлтийг шат дараалан хийнэ.</p>	<p>Гурванбулаг сумын эмнэлгийн барилгын гүйцэтгэгч АТТА-ЧР/ ХХК нь 385.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр ажил гүйцэтгэж байгаа ба туслан гүйцэтгэгчээр “Мон бармат” ХХК ажиллан усан хангамж, гадна, дотор дулааны шугам сүлжээний ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. ЭМСХ-2 төслийн хөрөнгө оруулалтаар Баацагаан, Богд сумын эмчийн орон сууцны барилга ашиглалтад орж, Шинэжинст, Баян-Өндөр сумын эмчийн орон сууц, гражийн барилгын ажил дуусч, улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. Баянцагаан сумын эмчийн орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт -30%/</b></p>
<p>1.3.7. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг боловсронгуй болгож, эмзэг бүлгийн болон хөдөөгийн хүн амд үйлчлэх явуулын үйлчилгээний тогтолцоог</p>	<p>Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг бүх сумдад 2 удаа, гар аргаар алт олборлогсдод 1 удаа зохион байгуулж, алслагдсан нутагт амьдарч буй 6673 хүн хамрагдаж, 25 хувийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авсан. Энэ үзлэгээр хүүхдийн амны хөндийн эрүүл мэндэд</p>

<p>бүрдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>онцгой анхаарч Дэлхийн Зөн ОУБ- тай хамтран “Эрүүл шүд –Сайхан инээмсэглэл” аяныг зохион байгуулж, 2307 хүүхдэд үзлэг хийж эмчилсэн. Хөдөө орон нутагт үзлэг явуулахын зэрэгцээ хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг давхар хийсэн нь иргэд, олон нийтэд хүрсэн ажил болсон.</p> <p>Сайн дурын дархлаажуулалтын санг сум тус бүрийн ХИЭС-ууд 300000 төгрөгөөр байгуулж, халдварт өвчнийг бууруулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>БЗХӨ/ХДХВ хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулснаар сумдын эмнэлгийн сувилагчдын БЗДХ/ХДХВ – ын талаарх мэдлэг дээшлэж, түргэвчилсэн оношлуураар богино хугацаанд ХДХВ – ын халдварыг илрүүлэх шинжилгээг гардан хийж суралцах, эргэн мэдээлэх харилцаа холбоог бий болголоо.</p> <p>Сумын эмнэлгүүдийг / 20 сум / 6000 ширхэг оношлуураар хангаж 2009 оны эхний 6 сарын байдлаар 9 сумын 823 хүн ХДХВ – илрүүлэх шинжилгээнд хамрагдснаас эерэг тохиолдол илрээгүй. Улирал бүр үйлчилгээний тайлан, шинжилгээнд хамруулсан тайланг авч нэгтгэн дүгнэж Монголын ДОХ – той тэмцэх нийгэмлэгт мэдээллэж байна.</p> <p>Глобаль сангийн дэмжлэгтэйгээр “Эхээс урагт тэмбүү өвчин халдварлах эрсдэлээс сэргийлэх нэг цэгийн үйлчилгээ” төсөл 2008-2013 он хүртэл хэрэгжихээр болж Аймгийн засаг даргын 167-н тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Төслийн үйл ажиллагааны хүрээнд 5071 америк долларын үнэ бүхий хурдавчилсан оношлуур, БЗДХ-г эмчлэх эм, тоног төхөөрөмж нийлүүлээд байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.3.8. Стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах бодлого баримтлан усны эх булгуудыг хамгаалах, орчны эрүүл ахуйг сайжруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</p>	<p>Сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд усны эх булгуудыг хамгаалах заалт оруулж 20 сум тус бүр 2 булгийн эхийг хамгаалсан. Аймгийн хэмжээнд Байдаг, Түй, Шар усан голуудын сав газрын зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж алт олборлолт хайгуул хийлгэхгүй байх арга хэмжээ авч ажилласан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p style="text-align: center;">Нийтийн биеийн тамирын ажил үйлчилгээг бүх нийтийг хамарсан хөдөлгөөн</p>	

болгон өрнүүлж, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлнэ.	
<p>1.4.1. Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлын үр нөлөөг сайжруулж, хамрах хүрээг өргөтгөж, иргэд, хүүхэд залуучууд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.</p>	<p>Биеийн Тамир спортын Газрын гадна талбайд 100,0 /Нэг зуун сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн орчин үеийн стандартын ногоон талбайг хийж ашиглалтад авсан.</p> <p>-МСҮТөвийн гадна талбайд нийтийн биеийн тамирын стандартын талбай, жижиг цэнгэлдэх хүрээлэн, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний “Бат-Идэр” ХХКомпанитай хамтарч ажилчдын сагсан бөмбөгийн гадна талбай, Эрдэнэмандал ахлах сургуулийн гадна талбай, ОБХэлтсийн дэргэд сагсан бөмбөг, гар бөмбөгийн задгай талбайг шинээр барьж байгуулсан.</p> <p>- Гэр хорооллыг олон нийтийн санаачлагаар хөгжүүлэх төслийн хүрээнд Баянхонгор сумын 5 дугаар багийн иргэдтэй хамтарч спорт тоглоомын гадна талбайг 6 дугаар гудамжинд байгуулахаар зураг төсвийн дагуу хийсэн. 6 дугаар багт хүүхдийн тоглоомын болон сагсан бөмбөгийн талбай байгуулах ажил эхлээд байна. Заалтын хүрээнд 130 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна талбайнууд хийгдэж нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин бүрдлээ.</p> <p>БТСГазрын дэргэд чийрэгжүүлэлт, бодибилдингийн клуб, шинээр нээгдэж үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн ИТХ-тай хамтран боксын “Бүргэд Баянхонгор” клубүүд шинээр тоног төхөөрөмж авчирч нээн ажиллуулж байна. Биеийн тамир спортын газрын дэргэд Бодибилдинг чийрэгжүүлэлтийн Стронг клубыг ажиллуулж нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт – 30%/</b></p>
<p>1.4.2.Олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртэх боломжтой спортын төрлүүдийг бодлогоор дэмжинэ.</p>	<p>Биеийн тамир спортын газрын менежментийг боловсронгуй болгох төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. “Үндэсний спортыг хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2009 оны 180 дугаар тогтоолоор баталгаажуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-30%/</b></p>

<p>1.4.3. Хүүхэд залуучуудын спортоор хичээллэлтийг дэмжиж улс, бүсийн уралдаан тэмцээнийг аймагтаа зохион байгуулна.</p>	<p>Аймагт улсын аварга шалгаруулах воллейболын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>1.4.4. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллага, биеийн тамир спортоор хичээллэх хөтөлбөр гарган ажилчдынхаа эрүүл мэнд, чийрэгжилтийг сайжруулах хэрэгсэл материалаар хангаж ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлнэ.</p>	<p>БТСГазар орон тооны Нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болж энэ чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө гарган улмаар албан байгууллагуудын ажилчдаар тусгай графикайн дагуу ажлын байрны дасгал хөдөлгөөнийг үе шаттай, системтэйгээр зааж өгөн cd гарын авлагаар хангаж ажиллав. Үүнд ЗДТГазар, ИТХурал, МШБанк, ХААН, ХАС, Татварын хэлтэс, НДХэлтэс, ЭМГазар, Холбоо, Сүлжээ ХХК, Прокурор, Шүүх, ХДТеатр, БТС-ын Газар. Агентлагууд ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийлгэсэн талаарх тайлангаа өгч байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт -30 %/</p>
<p>1.4.5 Өлзийт, Баянбулаг, Баянлиг, Жинст сумын спорт заалны барилга барих, Жаргалант сумын спорт заалны халаалт, Шаргалжуут, Баян-Овоо сумын спорт заалны барилгыг гүйцээн барих асуудлыг шийдвэрлэнэ.</p>	<p>БТСГазрын цогцолборт их засвар хийх ажлын хүрээнд 2009 оны улсын төсөвт 100.0 сая төгрөгийн засвар, Өлзийт сумын спорт заал ашиглалтад орсон, Шаргалжуут Тосгоны Спорт заал барилгын ажлыг /Баянтосон/ ХХК 126.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр гүйцэтгэж ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт -50%/</p>
<p>1.5.1 Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, тэдний хөгжлийг хангахад чиглэсэн бүхий л үйлчилгээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүүхдийн оролцоог дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 11 байгууллага тэргэнцэртэй иргэд саадгүй зорчих замтай болсон. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргаа сувилгааны төв” байгуулахад орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөг олгож, барилгыг барих тендерийн шалгаруулалт явагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 941 хүүхэд буюу 81.2 % нь сургууль, цэцэрлэгт хамрагдаж нийгэм хамт олон дунд сэргээгдэж сурах эрхээр нь хангагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй 46 иргэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдаж, 10 иргэн байнгын ажлын байраар хангагдаж, тусгай сангаас 3.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэлбэрийн 10 хүүхдийг эцэг, эхтэй нь Шаргалжуутад сувилуулахад 1.8 сая төгрөг зарцуулсан. Нөхөн сэргээх үйлчилгээнд 415 хүнийг хамруулж, эрүүл мэндийг нөхөн сэргээсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>

1.5.2. “Хүүхэд-залуучуудын хөгжлийн төв”-ийн барилгыг ашиглалтад оруулснаар хүүхдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх орчин нөхцлийг бүрдүүлнэ.	“Хүүхэд-залуучуудын хөгжлийн төв” –ийн барилгыг “Хөх бүрдний эх” ХХК ажил гүйцэтгэж ашиглалтад оруулж Хүүхдийн төлөө хэлтэс, Тэмүүжин театр үйл ажиллагаагаа явуулж байна.  /Хэрэгжилт-100%/
1.5.3 Аймгийн Засаг даргын дэргэд хүүхдийн зөвлөл байгуулан хүүхдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх талаар бодлого шийдвэр гаргахад тэдний санаа бодлыг тусган хүүхдийн оролцоог хөгжүүлнэ.	Аймгийн Засаг даргын 2009 оны 6 сарын 11-ны өдрийн 250 тоот захирамжаар “Хүүхдийн төлөө зөвлөл”, “Хүүхдийн сангийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталж зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлсэн.  /Хэрэгжилт-30%/
1.5.4.Хүүхэд залуучуудыг хүмүүжүүлж төлөвшүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр ажиллаж буй гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлагыг бүх талаар дэмжинэ.	Хүүхэд багачуудыг байгаль орчноо хайрлан хамгаалж, амьдрах орчноо цэвэр сайхан байлгаж эх орон, нутаг ус, байгалийн баялагаараа бахархах, зөв сэтгэхүйг төлөвшүүлэх зорилгоор 2 сарын аян зарлаж, аяны хүрээнд “Байгаль хамгаалал” сэдвээр эссэ бичлэг, гар зураг болон яруу найргийн тэмцээнүүдийг БСГ, БОАЖГ, Швейцарийн хөгжлийн агентлаг зохион байгуулсан. “Хүн бүр хүүхдийн төлөө санаачилга гаргацгаая” палкат гарган албан байгууллага, иргэдийг хүүхдийн сайн сайхны төлөө ажил үйлсэд уриалан дуудаж, аймгийн “Хүний хөгжлийн илтгэл”-д тусгасан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилт тавин үйл ажиллагаа зохион байгуулсан.  / Хэрэгжилт-30%/
1.5.5. Хүүхдийг дамлан худалдах, албадан хөдөлмөр хийлгэх, бэлгийн мөлжлөг болон бусад хууль бус үйл ажиллагаанд ашиглагдахаас урьдчилан сэргийлж, аюултай нөхцөлд ажиллуулах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгана.	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах цогц ажиллагаа, үүнд чиглэсэн нийгмийн түншлэлийг дэмжих нь үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Төр, ажил олгогч эздийн холбоо, ҮЭхолбоо хамтран хүүхдийн хөдөлмөрийг устгах арга хэмжээнүүдийг зохион байгуулж 388 хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлж, 435 хүүхдийн урьдчилан сэргийлсэн байна. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж, хангалттай үнэлгээ авсан.  /Хэрэгжилт-70%/
1.5.6. Ёс суртахуунтай иргэн төлөвшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж	Аймгийн засаг даргын 2009 оны 119 дүгээр захирамжаар хүүхэд хамгааллын ажлын хамтарсан баг байгуулагдан “Хүүхэд залуучуудын

хэрэгжүүлнэ.	хөгжил төлөвшил тулгамдсан асуудлыг шийдвэрлэх цогц үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулж 12-р сард ИТХурлаар батлуулсан. “Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийн чадавхи бэхжүүлэх”, “Хүүхдийн эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтууд, “Цодгор хүү” шатрын уралдаан, Өлзийт сумын сургуулийн санаачлагаар “Хүүхдийн хөгжил-2009” чуулган, “Дуулах өв – 2009” уралдаан зэргийг зохион байгуулж байна. <i>/Хэрэгжилт-70%/</i>
1.5.7. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	470 сонгогдсон өрхүүдээс 30 өрхийг жижиг зээл олгох үйлчилгээнд, 20 хүнийг гар утасны, 40 хүнийг гутал засварын мэргэжил олгох сургалтад, аж ахуй эрхлэх сургалтад 85 хүнийг, нийтийг хамарсан ажилд 188 хүнийг, ногоон ажлын байр хөтөлбөрт 165 хүнийг, 1 өрх 1 ажлын байр хөтөлбөрт 8 өрх, жижиг зээлийн хөнгөлөлтөд 8 өрх, олон нийтийн оролцоонд тушиглэсэн арга хэмжээнд 210 хүнийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 235 хүнийг тус тус хамруулан өрхийн орлогыг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 59.3 сая төгрөг зарцуулсан. Эдгээр өрхүүдээс 288 өрх ядуурлаас, 131 өрхийн амьжиргаа дээшилсэн байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
1.5.8. Хөдөлмөрийн насны хүн амыг зохистой ажлын байраар хангахад чиглэсэн бодлого баримтлан 6000-аас доошгүй ажилгүй иргэдийг ажилтай болгож, 2012 оны эцэст ажилгүйдлийн түвшинг 4.5 хувьд хүргэнэ.	2009 оны байдлаар 1999 хүнийг ажлын байранд зуучилснаас 1224 хүн байнгын зохистой ажлын байранд, 775 хүн түр ажлын байраар хангагдсан байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
1.5.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн 2500-аас доошгүй мэргэжилгүй иргэдийг мэргэжилтэй, 1500-аас доошгүй иргэнийг аж ахуй эрхлэх ур чадвартай болгож, тэдгээрийн 70-аас доошгүй хувийг ажлын байранд зуучилж	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 40.2 сая төгрөг зарцуулан 499 ажилгүй иргэнийг 13 мэргэжлээр сургаснаас 68.5 % буюу 365 иргэн ажлын байртай болж, засаг даргатай байгуулсан энэ бүтээгдэхүүний гүйцэтгэл 87.1 хувьтай байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>



байгуулан ашиглалтад оруулна. /төслөөр/	ийн орц гарц болон ариун цэврийн газрын тохижилтын ажлыг Европын Холбооны комисс болон Их Британы Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилттэй БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “ <b>сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах нь</b> ” багц төслийн хүрээнд хийж, ХБХ-дэд зориулсан цоо шинэ орчин нөхцлийг бүрдүүллээ.  /Хэрэгжилт-30%/
1.5.15. Тэтгэвэр, тэтгэмж олголтын дэвшилттэй аргыг нэвтрүүлнэ.	Тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож, итгэмжлэлээр авагчдын тоог багасгаж өөрсдийн биеэр ирж авах, өөрсдөө ирж авах боломжгүй хэвтрийн хүмүүсийг 2 жилд 1 удаа гэрт нь очиж итгэмжлэхийг сунгах арга хэмжээ авч ажиллаж байна.  /Хэрэгжилт-30%/
1.5.16. Иргэдийн сайн дурын даатгалд хамрах хүрээг өргөтгөж 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	2009 онд иргэдийн сайн дурын даатгалд 1190 хүн шинээр хамруулж 119,9 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулсан байна.  /Хэрэгжилт-50%/
1.5.17. Нийгмийн даатгалыг нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлж чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	Нийгмийн даатгалын Ерөнхий газарт нэг цэгийн үйлчилгээг бий болгох талаар санал хүргүүлж бэлтгэл ажлыг хангалаа. Эхний ээлжинд нэг цэгийн үйлчилгээнд шаардагдах тавилга тоног төхөөрөмжийг 6.0 сая төгрөгийн тендэр зарлаж, 3 материал ирснээс 1 материалыг шалгаруулан Ерөнхий газарт хүргүүлсэн. 2010 онд нэг цэгийн үйлчилгээг байгуулна.  /Хэрэгжилт-10%/
2.1.1. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, татварыг бүрэн хураах арга хэлбэрийг оновчтой болгох, татварын сургалт, сурталчилгааг өргөтгөж, чанар үр нөлөөг дээшлүүлэх, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох замаар төв орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд оршино.	Татварын Ерөнхий хуулийг шинээр мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан ТЕХ-ийн 5-р бүлэг, ТЕХ-ийн 7-р бүлэг ТЕХ-ийн 8-р бүлгийн заалтуудыг хэрэгжүүлэхээр ТЕГ-ын даргын тушаалаар баталсан журмуудыг мөрдлөг болгон татвар хураалтын түвшинг дээшлүүлэх, үйл ажиллагаагаа арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган сургалт семинарыг хийж ажилласан. Эхний 10 сарын байдлаар Татварын орлогын төлөвлөгөө 2465011,9 мянган төгрөг орохоос 2725443,5 мянган төгрөг орж 110,6 хувьтай биелсэн байна. Үүнд төвлөрсөн төсөвт төвлөрөх орлого 315515,6 мянган төгрөг орохоос 293873,6 мянган төгрөг орж төлөвлөөний биелэлт 93,1 хувь, орон нутгийн орлогын төлөвлөгөө 2123367,3 мянган төгрөг орохоос

	<p>2399618,3 мянган төгрөг орж төлөвлөгөөний биелэлт 113 хувьтай байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө дүнгээрээ биелэж байгаа боловч нэр төрлөөр тасарч байна. Энэ нь дараахь хүчин зүйл нөлөөлж байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орж малын татварыг сүүлийн хагас жилд чөлөөлсөнтэй холбогдож энэ татвар тасалдлаа. Мөн ашигт малтмалын нөөцийн төлбөр СЭЗЯ_аар хянагдан төрийн сангаар дараа сардаа төлбөр нь орж байгаа тул тасарлаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.1.2. Орон нутгийн ИТХ-аар хувь хэмжээг тогтоохоор УИХ-аар зөвшөөрсөн төлбөр хураамжийг шинэчлэн боловсруулж аймаг, сумын ИТХ-аар батлуулан мөрдөж ажилана.</p>	<p style="text-align: right;">/Хэрэгжилт-0%/</p>
<p>2.1.3. Мэдээлэл харилцаа, холбооны технологид суурилсан үйлчилгээг татвар төлөгчдөд эрчимтэй нэвтрүүлж, татварын албаны шинэтгэлийг үргэлжлүүлэн үр дүнд хүрэх зорилгоор “Цахим тайлан”-гийн системийг нэвтрүүлнэ.</p>	<p>Татварын Ерөнхий Газрын системд 2009 оныг “Цахим тайланг өргөжүүлж, бүртгэлийг төгөлдөржүүлэх” жил болгох зорилт тавьж татвар төлөгч аж ахуйн нэгжээс хууль тогтоомжийн дагуу улирал бүр хуулийн дагуу хугацаандаа тайлангаа өгч хэвшүүлэхэд ихээхэн анхаарч байна.. Цахим тайлангаар 2008 оны жилийн эцсээр 309 татварын тайлан хүлээн авч байсан бол 2009 оны 03 дугаар улиралд аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлан, НӨАТ-н тайлан, цалин хөлс түүнтэй адилтгах орлого /суутган-1/ зэрэг 1087 тайланг цахим хэлбэрээр хүлээн авсан нь өмнөх оноос 778 татвар төлөгчөөр өсч татвар төлөгчид мэдээллийн технологийг өргөнөөр ашиглаж байна. Татварын ерөнхий газрын вэб сайтад тавигдсан татварын хууль болон бусад хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, заавар журам, аргачлалыг хэлтсийн үйл ажилагаандаа ашиглахаас гадна татвар төлөгч иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад цаг тухайд хүргэн ажиллаж ирлээ. Цахим тайлан хүлээн авах, программд шивэлт хийх, хяналт тавихтай холбогдуулан байцаагч ажилчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, харилцааны соёлыг сайжруулах талаар ажлын байран дахь сургалтыг хийсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-70%/</p>
<p>2.1.4. Татвар төлөх нийгмийн сэтгэлгээг</p>	<p>“ Нэг цэг”-ийн үйлчилгээгээр татвар төлөгч нарт төрийн үйлчилгээг</p>

<p>хөгжүүлэх асуудалд ахиц гаргаж татварын албаны үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай, үр ашигтай болгоход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэн татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн “Нэг цэг”-ээс үйлчлэх үйлчилгээг боловсронгуй болгоно.</p>	<p>хөнгөн шуурхай нээлттэй, ил тод хүнд сурталгүй хүргэж байх зорилгоор 2009 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн тасгийн зохион байгуулалтад оруулан ажиллаж байна. Энэ зохион байгуулалтад орсноор татвар төлөгчдийн татварын талаарх эдийн засгийн ойлголт дээшилж татварын тайлангийн ирц, татварын ногдолт эрс дээшилсэн үр дүн гарч байна. /Хэрэгжилт-70%/</p>
<p>2.1.5. Татварын хэлтсийн хэмжээнд хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх , татварын улсын байцаагчдын мэргэжил үр чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үр бүтээлтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэн хөгжилтэй орнуудад ажилтнаа сургах , туршлага судлуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.</p>	<p>Татварын Ерөнхий Газраас 2009 оны 03 дугаар сарын 13- наас 14 нд Татвар хураалт үйлчилгээний хэлтсийн ТУБ М.Буянбадрах, Нийслэлийн татварын газрын ТУБ Л.Майцэцэг, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ТУБ н.Алтансүх нарын бүрэлдэхүүнтэй ажлын багийн хийсэн сургалтад сумдын болон аймгийн төвийн нийт 36 байцаагч, Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Татварын ерөнхий хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн стандарт”, хяналт шалгалтын ажлын талаар сургалт, ,Боловсрол соёлын газраас зарласан "Англи хэл сурцгаая" 3 сарын аян, "Монгол бичиг" сурцгаая аянд алба хаагчдыг бүрэн хамруулж ажиллаа. Ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшүүлэхэд анхааран ажиллаа. Ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар Татварын ерөнхий газрын сургалт судалгааны төтэй хамтран зайн сургалтыг 3 үе шаттайгаар хийж байна. Одоогийн байлаар 2 дахь үе шатны сургалтыг дуусгаж шалгалтыг мэргэжлийн байгууллага авч 3 дахь сургалт эхлээд байна. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.1.6. Татварын албаны материаллаг баазыг бэхжүүлэн сайжруулах талаар орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллаж дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p>	<p>Татварын албаны материаллаг баазыг дээшлүүлэх зорилгоор татварын орлого давуулан биелүүлсэн тохиолдолд давуулан биелүүлсэн орлогын 10%-иар урамшуулах заалтыг татварын хэлтсийн даргын үр дүнгийн гэрээнд тусгаж 2009 онд 20 сая төгрөгийн урамшуулал олгоод байна. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.2. Төсөв санхүү, статистик бүртгэл./ Санхүү бүртгэл статистик мэдээллийг нэгдсэн сүлжээнд бүрэн хамруулж нягтлан бодох бүртгэлийг олон улсын жишигт хүргэж, төсвийн зарцуулалтыг оновчтой болгоно. /</p>	
<p>2.2.1. Бүх сумдын төрийн санг нэгдсэн сүлжээнд бүрэн холбоно</p>	<p>Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Бөмбөгөр сумууд төрийн сангийн нэгдсэн сүлжээнд холбогдож одоо үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа 9 сум байна.</p>

	/Хэрэгжилт-50%/
2.2.2. Аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд олон улсын стандарт нэвтрэлтийг 90 хувьд хүргэнэ.	-2009 оны байдлаар 4 төсвийн байгууллага, 20 аж ахуйн нэгж байгууллагад /Бүх сумын 17 эргэлтийн эмийн сан, Авралын үг, Совин ХХК, Авто -18 ХХК/ санхүүгийн программ суулгаж үйл ажиллагаандаа мөрдөн санхүүгийн тайлан балансаа гаргаж байна. Мөн тооцоолон бодох компанитай хамтран төсвийн 178 байгууллагын санхүүгийн программд нэмэлт өөрчлөлт хийлгэж, программын 8 цагийн сургалтыг зохион байгууллаа.Стандарт нэвтрэлт 85 хувьтай байна.  /Хэрэгжилт-70%/
2.2.3. Төсвийн зарлагын норм нормативийг шинэчлэн оновчтой болгоно.	Төсвийг төлөвлөхдөө төрийн албан хаагч нэг бүрд ногдох зардлыг үндэслэн төлөвлөж байна. Цалингийн зардлыг төрийн албан хаагч нэг бүрээр, төрийн албанд ажилласан жил, зэрэг дэв, нэмэгдэл, нэмэгдэл хөлс тус бүрээр хянаж байна. Шатахууны зардлыг тухайн сумын аймгийн төвөөс алслагдсан байдал, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тооноос хамаарч төлөвлөж байна.Томилолтын зардлыг төлөвлөхдөө мөн төрийн албан хаагчийн тоо, аймгаас алслагдсан байдлыг харгалзаж байна. Бичиг хэрэг, нормын хувцас зөөлөн эдлэл,эд хогшил, ном хэвлэлийн зардлыг тухайн байгууллагын хэрэгцээн дээр нь үндэслэн төлөвлөж байна.  /Хэрэгжилт-70%/
2.2.4. Сумдад ажлын байр шинээр бий болгоход зориулж сум бүрийг хөгжлийн сан, мал аж ахуйн эрсдлийн сантай болгохыг дэмжинэ.	/Хэрэгжилт-0%/
2.2.5. Малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог бүрдүүлэх орон нутгийн төр захиргаа, даатгалын компаниуд малчид, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулж журмын дагуу нөхөн төлбөр олгоно.	МИДТ-ийг амжилттай туршиж хэрэгжүүлэхийн тулд Төсөл хэрэгжүүлэх нэгжээс /ТХН/ аймаг, сумдын Засаг даргын Тамгын газартай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулан ажиллалаа. МИДТ-өөс нийт малтай өрхийн 60,3 хувьд нь МИД-ын сургалт сурталчилгаа хийсэн байна. МИД-ын 2009 оны борлуулалтын улиралд даатгалын 4 компани ажиллаж 2444 борлуулалт хийгдсэн нь малчин өрхийн 21,10 хувийг эзэлж өмнөх оныхоос 4,68 хувиар өссөн. МИД-д 2009 онд нийт мал сүргийн 16,83 хувь МИД-д даатгуулсан байгаа бөгөөд өмнөх оныхоос

	<p>4,99 хувиар өссөн байна. 2009 оны хагас жилийн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 2008 оны нөхөн төлбөрт нийт 9 сумын 823 даатгуулагчдад 102,5 сая төгрөгийн нөхөн төлбөр олголоо.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.2.6. Албан ёсны статистикийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж сумдад орон тооны статистикч ажиллуулна.</p>	<p>Үндэсний Статистикийн Хорооны даргын 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 01/179 тоот тушаалаар батлагдсан албан ёсны Статистикийн мэдээ тайланг 1396 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 195 удаа авч тухайн мэдээлэл хариуцсан ажилтан шалган боловсруулж хэлтсийн дарга баталгаажуулан бүх мэдээг графикт хугацаанд нь бүрэн алдаа мадаггүй мэдээлсэн. 2009 оны эхний хагас жилд 12 суманд хяналтын ажлыг хийж, мэдээллийн үндэслэлийг шалган зааварчлав. Байцаагч нар нийт 42 ААНБ-д хяналт шалгалтын ажлыг хийсэн байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.2.7. Хүн ам, орон сууцны улсын тооллогын бэлтгэлийг сайтар ханган явуулж үр дүнг тооцох, мэдээллийн санг бүрдүүлнэ.</p>	<p>Хүн ам орон сууцны улсын тооллогын бэлтгэлийг хангах, зохион байгуулан явуулах улсын комисс Монгол улсын ерөнхий сайдаар, аймгийн комисс аймгийн Засаг даргаар ахлуулан байгуулагдаж ажиллаж байгаа бөгөөд Сумдын тооллогын комисс, аймгийн түр товчооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 242 тоот захирамжаар батлан хэрэгжүүлж энэ дагуу нийт сумдад комисс, түр товчоод байгуулагдаад байна. Аймгийн тооллогын комиссын анхны хуралдаанаар сумдыг гишүүдэд хуваарилан хариуцуулж ажиллаж байна. Орон сууц, хашаа, гудамжны нэр хаягийг цэгцлэх, иргэний анхан шатны бүртгэлийг чанаржуулах талаар төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийг сурталчилан таниулах ажлыг хийж, сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, иргэний бүртгэл мэдээллийн ажилтан нарын сургалт семинарыг зохион байгуулж сумынхыг бүрэн хамруулав. Хүн ам, орон сууцны тооллого явагдах хугацаа, түүний зорилго, ач холбогдол, иргэдийн үүргийн талаар сурталчлан таниулах зорилгоор аймгийн сонинд 11, аймгийн телевизээр 3 удаа сурталчилгаа хийв. Хүн ам өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтөлөлтийг сайжруулах чиг үүргийг өгч улирал тутам мэдээллийн санг авч шалгах ажлыг зохион байгуулж байна. УИХ-аас ХАОСТ-ын товыг</p>

	<p>өөрчлөн тогтоосноор уг ажил 2010 оны 11-р сард явагдахаар болж хойшилсон.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.2.8. Аймгийн эдийн засаг нийгмийн статистикийн мэдээллийн үзүүлэлтийн тоо,нэр төрлийг нэмэгдүүлж, хамралтыг сайжруулах Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийнхээ удирдлагын үйл ажиллагаанд шаардлагатай зарим мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр боловсруулан ҮСХороогоор зөвшөөрүүлэн мөрдөж мэдээллийн сантай болно</p>	<p>Аймгийн өрх, хүн ам, ХАА болон бусад салбарын мэдээллийн санг бүрэн бүрдүүлж хагас, бүтэн жилээр баяжилтыг хийн ажиллах боломжтой болсон. Аймаг,орон нутгийн хөгжлийг тодорхойлон харуулж чадахуйц үзүүлэлтүүдийн систем боловсруулах ажлыг эхэлж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид болон Засаг даргын зөвлөлийн гишүүдийн саналыг авч тусган боловсруулж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.3.1. Үйлдвэр үйлчилгээ, иргэдийн ахуйн хэрэглээний зээл олголтыг эдийн засгийн бодит өсөлтөд уялдуулан нэмэгдүүлнэ</p>	<p>2009 онд Монгол Шуудан банк зээл олголтоо хязгаарлаж, “ХААН”, “ХАС”, “Хадгаламж” банкууд үйлдвэр үйлчилгээ, иргэдийн ахуйн хэрэглээний зээл олголтын тасалдлыг бүрэн арилгаж ажилласан. 2010 оны 12 сарын 31-ны байдлаар банкуудын зээлийн багц 19,7 тэрбум төгрөг байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.3.2. Банкны нэгжийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөнө.</p>	<p>Сумуудад франчайзын үйлчилгээ явуулах,үйлчилгээ нээх талаар судалгаа хийж санал солилцсон. Бууцагаан суманд 2009 оны 4 сард “Буянт Богдын хишиг” нэртэй ХЗХоршоо байгуулагдсан. Хоршоо 21 гишүүнтэй, 1050.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр байгуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.3.3. Төлбөр тооцоонд бэлэн бус тооцоогоор гүйцэтгэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.</p>	<p>Банкууд хүүхдийн мөнгө, халамж, иргэдийн мөнгөн гуйвуулгын 20 хувийг картжуулсан мэдээтэй байна. Хас банк “Амар” үйлчилгээ, ХААН банк телефон банкны үйлчилгээг нэвтрүүлээд байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-90%/</p>
<p>2.3.4. Банкны байгууллагуудыг онлайн системд бүрэн хамруулна.</p>	<p>ХААН, Монгол Шуудан банкны хөдөө сумын болон аймгийн төвийн бүх тооцооны төвүүд онлайн системд бүрэн нэвтрэн, төлбөр тооцоог хурдан шуурхай хийх боломж бүрдсэн</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
<p>2.4.1. Баянхонгор суманд эрчим хүчний</p>	<p>Баянхонгор сумын шинээр бий болсон гудамж, хашаа болон бусад</p>

<p>түгээх сүлжээний найдвартай байдлыг сайжруулж 6 ширхэг дэд станцыг суурилуулна.</p>	<p>цахилгаан эх үүсвэргүй хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам сүлжээ барьж байгуулах зорилгоор Цахирын 7- багийн нутаг Хөх толгойн чиглэлд 13.3 сая төгрөгийн 2 дэд станц , шугам сүлжээ шинээр барьж ашиглалтад оруулан нийтдээ 57 айл өрх хэрэглэгчдийг шинээр цахилгаан эрчим хүчээр ханган ажилласан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.4.2. Шаргалжуут тосгон, Өлзийт, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал, Заг сумын төвийн 0.4 кв-ийн шугам сүлжээ, дэд станцад засвар шинэчлэл хийж хэмжүүрийн хэрэгслээр хангаж Заг, Гурванбулагийн 10 кв-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг засварлана.</p>	<p>Шаргалжуут тосгоны 0,4 кв-ийн шугамыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 11000,0 төгрөгөөр хийсэн Бөмбөгөр-Заг сумдын 35 кв-ын 2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий эрчим хүчний байнгын эх үүсвэрээр хангах цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ, дэд станц, Жаргалант, Гурванбулаг сумын 10 кв-ын цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ байнгын ашиглалтад орсон.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.4.3. Шинэжинст, Баянцагаан, Баян-Өндөр сумдын нар салхины эрчим хүчний үүсвэрийн найдвартай ажиллагааг хангахын зэрэгцээ цахилгаан дамжуулах агаарын шугаманд холбох эхлэлийг тавина.</p>	<p>Шинэжинст, Баянцагаан, Баян-Өндөр сумдын нар салхины эрчим хүчний эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах талаар мэргэжлийн баг сумдад ажиллан шаардлагатай дизель моторыг балансаас балансад шилжүүлэх асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хүргүүлээд байна. Одоогоор Шинэжинст сумын 2 сэнсэн хөдөлгүүр, Баянцагаан, Баян-Өндөр сумдын тус тус 3-н сэнсэн хөдөлгүүр ажиллахгүй байгааг засварлуулахаар гүйцэтгэгч байгууллагуудад албан тоотой уламжлаад байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.4.4. Аймгийн төвийн хэрэглэгчдийг цагийн тарифт тоолуурт шилжүүлнэ.</p>	<p>Цагийн тарифт тоолуурт шилжүүлэх санлыг яаманд удаа дараа тавьж байгаа ч одоогоор шийдэгдээгүй.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-10%/</p>
<p>2.4.5. Бууцагаан-Хүрээмарал сумын 43 км , Хүрээмарал-Баянбулаг сумын 52 км 15 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг дэд станцын хамт шинээр барьж ашиглалтад оруулна.</p>	<p>2010 оны төсөвт суугдсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-10%/</p>
<p>2.4.6. Арвайхээр- Баянхонгорийн 184 км хатуу хучилттай авто замыг 2008-2010 онд</p>	<p>Дэлхийн банкны төслөөр 2005-2007 онд Арвайхээр-Баянхонгорын хоорондох 100 км авто замын гүүр, гарц хоолой, хайрган замыг хийж</p>

<p>улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p>дуусган ашиглалтад оруулан, Арвайхээр хотоос эхлэн 23 км асфальтан замын барилга угсралтын ажил нь 2992.2 мян/ төгрөгийн төсөвт өртөгтэй, 2007 онд 2502.2 мян/ төг, 2008 онд 489.6 мян/ төг, 2009 онд 493.0 мян/ төг-ийн барилга угсралтын ажил тус тус гүйцэтгэн ашиглалтад орууллаа.</p> <p>Баянхонгор- Арвайхээрын 27 км хатуу хучилттай замын барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг 5 тэрбум 500 сая төгрөг, 2007-2008 онд 3050,0 төгрөгийн газар шорооны ажил гүйцэтгэсэн.</p> <p>2009 онд 2,450 мян/төгрөг ийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдан замын ажил хийгдсэн .</p> <p>Баянхонгор -Нарийн тээлийн 50 км хатуу хучилттай авто зам барих ажлын нийт төсөвт өртөг нь 10 тэрбум төгрөг, улсын хөрөнгө оруулалтаар 2008 онд 500 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн, 2009 онд 9500,0 төгрөгийн барилга угсралтын ажил хийхээр санхүүжилтийн эх үүсвэр батлагдан 30 км замыг “ Чайлган” ХХК, дараагийн 20 км замын ажлыг “АЗЗА” ХХК хийхээр гэрээ байгуулан ажиллаж 3.0 тэрбум төгрөгийн угсралтын ажил гүйцэтгээд байна.</p> <p>Арвайхээр Баянхонгор чиглэлийн 107 км замын хөрөнгийн асуудал Улсын Их Хурлын хаврын чуулганд оруулахаар хүлээгдэж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.4.7 Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах төсөл”-ийн хүрээнд малчин өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангана.</p>	<p>“Буман нарны гэрэл” үндэсний хөтөлбөрийн 2-р шатны хүрээнд 2007 онд 1200 малчин өрхийг нарны зайн цахилгаан үүсвэрээр хангасан.2003, 2004 онд авсан нарны гэрлийн үнийн дутууг шийдвэрлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулснаар 479.0 сая төгрөгийн төлбөр барагдуулахаас 140.9 сая төгрөгийг барагдуулан төвлөрүүлж төлбөрийн барагдуулалтын хувь 17 байсныг 31 хувьд хүргэсэн.Сүүлийн 3 жилд СЭХҮндэсний төвөөс 1095 ш, аймгийн борлуулалт үйлчилгээний төвөөс 1586 ш гэрэл тус тус нийлүүлэгдэн нийтдээ 2681 малчин айл өрх нарны зайн гэрэлтэй боллоо.Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчнийг ашиглах төсөл”ийн хүрээнд 2010 онд нийтдээ 2048 өрх малчин өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангах захиалга</p>

	хүргүүлэн ажиллаж байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.4.8 Бөмбөгөр-Загийн чиглэлийн 35 кв-ийн ЦДАШ-ийг ашиглалтад оруулснаар Заг, Жаргалант, Гурванбулаг сумдыг цахилгааны найдвартай эх үүсгүүрээр хангах үндсийг тавина.	Бөмбөгөр-Заг сумдын 35 кв-ын 2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий эрчим хүчний байнгын эх үүсвэрээр хангах цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ, дэд станц, Жаргалант Гурванбулаг сумын 10 кв-ын цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ байнгын ашиглалтад орсон. <i>/Хэрэгжилт-100%/</i>
2.4.9 Аймгийн төвийн хатуу хучилттай замыг 18 км -ээр, явган хүний замыг 12 км-ээр уртасгаж, гудамж талбайд ая тохитой орчин бүрдүүлж, орон нутгийн замын засвар үйлчилгээг жил бүрийн төсөвт тусган гүйцэтгэнэ.	2009 онд Замын сангийн хөрөнгөөр Баянхонгор сумын авто замын нөхөөс, хуучин хашлагыг засварлахад 5 сая 827000 төгрөг, Цэнгэлдэх хүрээлэн хүртэл 1 км асфальтан замын барилга угсралтын ажилд 193 сая төгрөг, хотын төвийн явган хүний зам тавих ажилд 25 сая 200 мянган төгрөгийн ажлын зураг төсвийг хийлгэн, ИТХТ-ийн хуралд оруулан батлуулсан. Аймгийн төвд 0.64 км авто зам, засварын ажлыг “Мапроуд” ХХК Спорт хорооны араар төв замаас цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн талын зам хүртэл гүйцэтгэхээр 194.9 сая төгрөгийн гэрээ байгуулан замын ажлыг хийсэн. Гүйцэтгэл 80 хувьтай байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.4.10. 2009 оныг жижиг дунд үйлдвэрийн жил болгосныг дэмжин, бизнес инкубатор байгуулж жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүү, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн Засаг даргын 2009 оны 214-р захирамжаар жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэлээр ирүүлсэн төслүүдэд хөнгөлөттэй зээл олгох ажлыг хэлэлцэн зохион байгуулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг нийтдээ 11 удаа хуралдаж нийт ирүүлсэн 1,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 76 төслийг хугацаанд нь хэлэлцэн 815,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төслийг шалгаруулан банкинд хүргүүлсэн. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.4.11. Барилгын материал үйлдвэрлэх, цэвэр ус савлах, хог боловсруулах, эсгий, эсгий бүтээгдэхүүн боловсруулах, цементийн үйлдвэр барих, Бумбатын тоосгоны үйлдвэрийг сэргээн ажиллуулах, бусад жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх ажлыг	Барилгын материал үйлдвэрлэх 7 төслийг хурлаар хэлэцүүлэн санхүүжилт олгох шийдвэр гаргуулан ХАС банкинд хүргүүлснээс 6 төсөлд санхүүжилт олгох ажил бүрэн хийгдсэн. <i>/Хэрэгжилт-30%/</i>

дэмжинэ.	
2.4.12. Үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэлийг нэмэгдүүлж төрөл бүрийн төсөл боловсруулан гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.	Улсын төсвөөс хуваарилагдсан хөрөнгө, ХАС банкнаас гаргах хөрөнгийг бүрэн шийдвэрлэж нийт 774,3 сая төгрөгийн зээлийг төсөл хэрэгжүүлэгч 50 иргэн аж ахуйн нэгжид олголоо.  /Хэрэгжилт-30%/
2.4.13. Авто тээврийн хэрэгслийн засвар, бусад төрлийн үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг нь орчин үеийн шаардлагад нийцүүлнэ.	Баянхонгор суманд авто засвар бусад төрлийн үйлчилгээ эрхэлж байгаа 17, авто сэлбэгийн худалдаа эрхэлж буй 28 аж ахуйн нэгж, иргэд үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, заавар зөвлөгөө өгөх ажлын хэсгийг АТХУлсын байцаагч болон оношлогч инженерүүдийн бүрэлдхүүнтэйгээр байгуулж, 12 дугаар сард эхний ээлжинд 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж авто үйлчилгээний газруудын ангилал зэрэглэлийг тогтоож ажиллагсдыг нь мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээ авсан  /Хэрэгжилт-30%/
2.4.14. Бөөний худалдааны сүлжээ түүхий эдийн бирж, баруун аймгуудын худалдаа үйлчилгээний төвийг байгуулна.	Аймгийн төвд “Баруун бүсийн худалдааны төв”-ийн барилгын ажил 70 хувьтай баригдаж байна.  /Хэрэгжилт-70%/
2.4.15. Баянхонгор сумын гэр хорооллын нөхцөлийг сайжруулах зорилгоор ариутгах татуурга, цэвэр усны инженерийн шугам сүлжээг өргөтгөх ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж эхэлнэ.	Баянхонгор сумын цэвэрлэх байгууламжийг шинэчилж, өргөтгөх барилга угсралтын ажлын 1 тэрбум 580 сая төгрөгийн зураг төсвийг улсын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын “ИНЖ- байгууламж” зураг төсвийн байгууллагаар хийлгэсэн. Барилга угсралтын ажлын санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр УИХ, холбогдох яамдын сайд, байгууллагуудад албан тоотоор санал хүргүүлээд байна.  /Хэрэгжилт-30%/
2.4.16. Засгийн газрын “100000 айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	“Хонгор-1000” орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажлын хэсэг байгуулагдаад байна.  /Хэрэгжилт-30%/

2.4.17.Газрын доорх байгууламжийг тоолж бүртгэлжүүлэн засварлах, шинэчлэх ажлыг зохион байгуулна.	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ГХГЗЗГ-т асуудал тавиад байна. /Хэрэгжилт-10%/
2.4.18.Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ. /Дэлхийн банкны санхүүжилтээр/	Азийн Хөгжлийн банкны “Нийтийн аж ахуйг сайжруулах “ төслийн хүрээнд аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэн өргөтгөх, гэр хороололын цэвэр усны хангамжийн 4.5 км шугам сүлжээг шинээр байгуулах зэрэгт нийт 390 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн 2010-2012 онд төсөл хэрэгжүүлэхээр болсон. /Хэрэгжилт-30%/
2.5.1. Эрдэнэцогт, Баян-Овоо, Галуут, Богд, Жинст, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Өлзийт зэрэг шилэн кабельд холбогдсон сумдад өндөр хурдны интернетийн үйлчилгээ хүргэнэ.	Эрдэнэцогт, Баян-Овоо, Галуут, Богд, Жинст, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Өлзийт сумдын шилэн кабелийн угсралтын ажил хийгдэж өндөр хурдны интернетийн үйлчилгээ үзүүлж байна /Хэрэгжилт-100%/
2.5.2. Шуудангийн үйлчилгээний бүсчлэлийн ЗИП кодын хэрэгжилтийг хангана.	Шуудангийн үйлчилгээний бүсчлэлийн ЗИП коджуулах бэлтгэл ажил хийгдэж байна. /Хэрэгжилт-10%/
2.5.3. Бүх сум суурин газруудыг үүрэн телефоны үйлчилгээтэй болгоно.	Аймгийн бүх сумууд үүрэн телефоны үйлчилгээтэй боллоо. Үүнд : Өлзийт, Баянлиг, Баянговь, Баянцагаан, Баянбулаг, Жаргалант сумууд моби, Жинст, Богд, Баацагаан, Эрдэнэцогт, Баян-овоо сумд скайтель, Бууцагаан, Хүрээмарал, Бөмбөгөр, Гурванбулаг Жи-Мобайлийн үйлчилгээгээр тус тус хангагдсан. /Хэрэгжилт-100%/
2.5.4. Шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлж, орон нутагт шуудан, зорчигч тээвэрлэлтийг аюулгүй найдвартай баталгаатай болгох үүднээс шуудангийн автопарк шинэчилэхэд дэмжлэг үзүүлнэ.	Шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлж хөдөө орон нутаг, сумдад долоо хоногт 1 удаа болгоод байна. /Хэрэгжилт-50%/
<b>2.6. Тээвэр</b>	
<b>Зорчигч, ачаа тээврийн үйлчилгээг шуурхай, найдвартай болгоно</b>	
2.6.1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж, хот	Хот хоорондын зорчигч тээвэрт 2008 оноос дунд оврын 28 суудалтай автобус, 2009 оноос 45 суудалтай автобус тус тус үйлчилж байна.

<p>хоорондын зорчигч тээвэрт их болон дунд багтаамжийн автобусны үйлчилгээг өргөжүүлэн, онлайн сүлжээнд бүрэн хамруулна.</p>	<p>Хот хоорондын нийтийн тээврийн удирдлага зохицуулалтыг онлайн сүлжээнд бүрэн хамруулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан. /Хэрэгжилт-50%/</p>
<p>2.6.2. Орон нутгийн нийтийн тээврийг хөгжүүлж, хотын дотор дунд бага багтаамжийн автобус, таксигаар тогтоосон чиглэл, цагийн хуваарийн дагуу үйлчилнэ.</p>	<p>Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийн дунд сонгон шалгаруулалт зарлан, “ГАЗ-ОД” ХХК нь 25 хүний суудалтай Солонгос улсын ASIA маркийн автобусыг 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2 чиглэлд туршилтын журмаар явуулж эхлээд байна. “Бодь хүч” ХХК нь суудлын 4 авто машинаар дуудлагын такси үйлчилгээг нэвтрүүллээ. /Хэрэгжилт-90%/</p>
<p>2.6.3. Нийтийн зорчигч тээвэр, техникийн хяналт оношлогооны төвлөрсөн Автовокзалыг өргөжүүлж, зорчигчийн хүлээх танхим, тээш хадгалах, илгээх үйлчилгээг бий болгоно.</p>	<p>Зорчигчдын тийз бичих касс, зорчигчдын хүлээлгийн өрөөг тохижуулан ажиллуулж байна. Зорчигчийн тийзийг онлайн сүлжээнд бүрэн хамрагдснаар Улаанбаатар болон өөр аймгаас гарсан автобусанд зорчигч иргэдийн нэр, регистрийн дугаарыг мэдэхийн зэрэгцээ тийзийг онлайн сүлжээгээр урьдчилан бүрдүүлж авах боломж бүрдлээ. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.6.4. Техникийн хяналт оношлогооны багаж хэрэгсэлийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг чанаржуулан, утаа зайлуулах төхөөрөмж суурилуулан, техникийн хувьд бүрэн бус, хорт утаа ихтэй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.</p>	<p>- Техникийн хяналт оношлогооны үйл ажиллагааг чанаржуулан, тээврийн хэрэгслэлийн хувьд бүрэн бус, хорт утаа ихтэй тээврийн хэрэгслэлийг хөдөлгөөнд оролцуулах зорилгоор 3-р сард оношлогооны байранд засвар үйлчилгээ хийсэн. - Нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн үзлэгийг Баянхонгор тээвэрчин хоршооны 42 авто машин, “Лотот” ХХК-ний дунд болон бага оврын 4 автобусанд үзлэг оношлогоог хийж MNS4598-20038 нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ MNS5012-2001 стандартад тавигдах шаардлагыг хангуулан ажиллаж байна. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.7. Стандарт хэмжил зүй/ Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд стандарт, баталгаажуулалт, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ./</p>	
<p>2.7.1. Хүнсний бүтээгдэхүүн, барилга, ханын материалын шинжилгээний лаборатори байгуулна.</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүнд хуучин лабораторийн хүрээнд шинжилгээ хийж байгаа бөгөөд барилгын материалын шинжилгээний лаборатори байгуулахаар төлөвлөсөн ч хөрөнгийн асуудлаас шалтгаалан хэрэгжээгүй.</p>

	/Хэрэгжилт-10%/
2.7.2. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Олон Улсын ISO -9000 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж эхлүүлнэ.	- Стандартын товч танилцуулгыг сургалтанд ашиглах зорилгоор бэлтгэн холбогдох удирдлагуудад танилцуулсан.  /Хэрэгжилт-10%/
2.7.3. Аймагт үйлдвэрлэж буй бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдэд стандарт мөрдүүлж. “Тохирлын гэрчилгээ” олгуулна.	Аймгийн төв хөдөөд шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа 5 газрыг стандартаар хангаж, хүний эрүүл мэндэд хор нөлөө үзүүлж болзошгүй 13 нэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний 64 цэг салбарт стандарт мөрдүүлэн тохирлын гэрчилгээ олголоо.  /Хэрэгжилт-30%/
2.8.1. Сүү цагаан идээ, ингэний сүү, ундаа савлах, мах боловсруулах, ноос угаах, хүнсний ногоо боловсруулах, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг дэмжинэ.	Аймгийн төвд “Баруун шанд” ХХК-д хоногт 4,0 тн сүү боловсруулах үйлдвэр, Баянлиг суманд өдөрт 500 литр сүү савлах цехийг ашиглалтанд оруулан ажиллаж байна. ХХААХҮЯ-ны Сүү үндэсний хөтөлбөрийн газартай хамтарч ингэний ундааг савлах тоног төхөөрөмжийг Баянлиг суманд бүрэн суурилуулж ажиллуулж байна. Мөн ингэний ундааг савлаж үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх иж бүрэн тоног төхөөрөмжийг авах зориулалтаар 20,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгон ажиллав.  /Хэрэгжилт-30%/
2.8.2. “Нэг баг нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөний үйл ажиллагааг эрчимжүүлж, бренд бүтээгдэхүүнүүдийг патентжуулах ажлыг зохион байгуулж, брэнд бүтээгдэхүүний маркетинг менежментийг сайжруулна.	Сумдын Засаг дарга нарт төмсний үрийн сан байгуулах талаар удирдамж үүрэг даалгавар өгөгдсөн. Төлөвлөсөн хөрөнгө хүрэлцэхгүйгээс сум бүр 4 тн үрийн нөөц бүрдүүлэх боломжгүй болсон ч үрийн төмсний санг бүрдүүлэх чиглэлээр сум бүрт эхлэл тавигдсан.  /Хэрэгжилт-30%/
<b>2.8.3. Төмсний үрийн хэрэгцээг өөрийн аймгийн байгаль цаг уурын нөхцөлд нутагшсан үрээр бүрдүүлж, төмсний үрийн сан байгуулж, аймгийн төмсний хэрэгцээний 70 хувь, нарийн ногооны 25 хувийг хангана.</b>	2008 оны дүнгээр мах, сүү цагаан идээг 100%, төмс, хүнсний ногооны 50,2%, цөцгийн тос, жимс, жимсгэний 18,0 %-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан дүнтэй байв. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэмжээ урьд оноос нэмэгдэж, мах сүү, цагаан идээг бүрэн, төмсний 63,5, хүнсний ногооны 23,4, цөцгийн тос, жимс, жимсгэний 20 гаруй хувийг тус тус хангаад байна.  /Хэрэгжилт-30%/

<p>2.8.4. Төв суурин газрын хүн амын мах, сүүний хэрэгцээг хангах зорилгоор фермерийн аж ахуй байгуулах, өрхийн аж ахуй эрхлэх төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалахыг төрийн бодлогоор дэмжинэ.</p>	<p>Бууцагаан суманд зохион байгуулагдсан 20 сумын “Тариаланчдын зөвлөгөөн”-ий үеэр “Түмэн сүйх” ХХК-ны агрономич Я.Оюнчимэг, “ЖиСаОй” ХХК-ны агрономич Ч.Уранбилэг нар хамгаалагдсан хөрсний тариалангийн сургалтыг явуулж, аймгийн ИТХурлаас гарын авалга, зарим үрээр хангав. Улсын тэргүүний тариаланч Д.Батгэрэлийн талбайд өдөрлөг зохиож, удирдах ажилтан, мэргэжилтэн 85 хүн оролцов. Шинэжинст сумын Эхийн голын тариаланчдын уулзалтыг 4-р сард ХААИС-тай хамтран зохион байгуулж өргөст хэмхийн үр үржүүлэх, говийн унаган моддын үржүүлгийн 4 га газар байгуулах ажлуудыг эхлэв. Мөн Хүрээмарал сумын Мөрөнгийн талбайд талбайн өдөрлөг зохион байгууллаа. Газар тариалангийн чиглэлийн нийт 68 сургалтанд 1254 тариаланч хамрагдаж, 3260 хүнд технологийн зөвлөлгөөн өгсөн байна. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.5. Чацарганы аж ахуй эрхлэх нөхцөл бололцоог бүрдүүлж, дэмжиж ажиллана.</p>	<p>Чацарганы аж ахуй байгуулах ажил энэ оны үндсэн чиглэлд тодорхой сумууд дээр байгуулахаар тусгагдсан болно. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.6. Мал сүргийн бүтэц, хээлтэгч хээлтүүлэгчийн зохистой харьцааг хадгалж малын тоо ялангуяа ямааны өсөлтийг тодорхой түвшинд барьснаар бүх малын 20 хүртэлх хувийг цөм сүргийн сайн чанарын малаар бүрдүүлнэ.</p>	<p>“Цөм сүрэгтэн манлай малчдын аймгийн зөвлөлгөөн”-ийг төсөв хөрөнгийн байдлаас шалтгаалан зохион байгуулаагүй болно. Харин Богд, Жинст, Баянлиг, Заг, Баянбулаг суманд “Манлай малчдын зөвлөлгөөн”, бүх сумдад “Малчид төлчдийн зөвлөлгөөн” зохион байгуулагдах үеэр цөм сүргийн болон малын үржил, селекцийн талаар тодорхой мэдээлэл суртчилгаа явагдсан болно. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.7. Мал аж ахуйг аливаа эрсдэлээс хамгаалах тогтолцоо бүрдүүлж материаллаг баазыг бэхжүүлж өргөтгөх бодлого барина. /Даатгал, Мал эмнэлгийн бүхий л арга хэмжээ, хашаа хороо, худаг уст цэг, бэлчээр ашиглалтыг сайжруулж, өвс тэжээл бэлтгэх /</p>	<p>- Аймгийн Засаг даргын 2009 оны 182 дугаар захирамжаар “Эрсдэлгүй мал аж ахуйн төлөө”, “Төмс, хүнсний ногооны зоорь, хүлэмж” уралдааны болзлыг баталж бүх сумдад хүргүүлж, мөрдөж эхэлсэн. Энэ онд хадлан 2393 тн, гар тэжээл 277 тн-г бэлтгэж, инженерийн хийцтэй уст цэг 22, гар худаг 51-г гаргаж, малын хашаа хороо 214-г шинээр барьсан. /Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.8. Баянхонгор аймагт мал аж ахуйг эрчимжүүлэх хөтөлбөр боловсруулж</p>	<p>2006-2010 онд хэрэгжүүлэх “Мал аж ахуйг эрчимжүүлэх хөтөлбөр” 3 бүлэг, 54 заалтай боловсруулагдаж жил бүр биелэлтийг нь тооцон</p>

хэрэгжүүлнэ	ажиллаж байна. <i>/Хэрэгжилт-70%/</i>
2.8.9. Шинэжинст, Бөмбөгөр, Баянлиг, Өлзийт, Эрдэнэцогт, Галуут зэрэг сумыг түшиглэн хээлтүүлэгч малын мэдээллийн сан бүрдүүлэх, бусад сумдыг хээлтүүлэгчээр хангах чиглэл барина.	Нэр заагдсан сумуудад 2423 хээлтэгчийг бүртгэлжүүлэн гэрчилгээ олгож , мэдээллийн санд бүртгэн зэргэлдээ сумуудыг хээлтэгчээр хангах бодлого баримтлан ажиллаж байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.8.10. Сумдын агропаркуудын үйл ажиллагааг тогтмолжуулж, тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, өрхийн үйл ажиллагааг дэмжинэ.	Атрын 3-р аяны хүрээнд сум бүрт агропаркууд байгуулсан. Цаашид төслийн ашиглалтыг сайжруулж, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг болгох, техник зохион байгуулалтын арга хэмжээ авахад анхаарч байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.8.11 Таримал тэжээл, хашаалсан нөөц бэлчээрийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлж, газар тариалан мал аж ахуй хосолсон үйлдвэрлэлийг эрчимжүүлж, тэжээлийн ургамал тариалах, тэжээл үйлдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн Засаг даргын 2009 оны 182 дугаар захирамжаар “Эрсдэлгүй мал аж ахуйн төлөө”, “Төмс, хүнсний ногооны зоорь, хүлэмж” уралдааны болзлыг баталж бүх сумдад хүргүүлж, мөрдөж эхэлсэн. Энэ онд хадлан 2393 тн, гар тэжээл 277 тн-г бэлтгэсэн. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.8.12. Инженерийн хийцтэй уст цэгийн хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр гаргах болон сэргээн засварлах хурдгийн тоог нэмэгдүүлж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.	Инженерийн хийцтэй уст цэг 22, гар худаг 51-г гаргаж, малын хашаа хороо 214-г шинээр барьжээ. <i>/Хэрэгжилт-30%/</i>
2.8.13. Услалтын системүүдийн ашиглалтыг сайжруулж шинээр Бөмбөгөр, Заг, Бууцагаан сумдын газар тариалан эрхэлдэг газарт услалтын систем байгуулж, Баацагааны Хөх эргийн услалтын системийг сэргээн засварлах/төслөөр/, далан ,хөв байгуулахыг дэмжин ажиллана.	Шаргалжуутын услалтын систем 172 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2009 онд ашиглалтанд хүлээн авсан, Таван толгойн услалтын системийн зураг төслийг “Агдуут булаг”хоршоо хийж улсын тендерт оролцсон боловч шалгараагүй. Эхийн голын услалтын системийг сэргээн засварлах ажлыг тус аймгийн “Номин хишиг” ХХК гүйцэтгэн хүлээлгэж өгөв.Энэ нь 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэв. Бууцагааны Өлзийт голын услалтын системийн зураг хийгдсэн. Бор балгасны услалтын системийг 2008 онд хүлээн аваад ашиглагдаж байгаа. <i>/Хэрэгжилт-30%/</i>

<p>2.8.14. Халдварт өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээний захиалгыг жил бүр нэмэгдүүлж, мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлнэ.</p>	<p>Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний захиалгыг эпизотологийн судалгааг үндэслэн хийв. Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн төлөвлөгөөт хэмжээнд 33,5 мянган мал хамрагдаж 106,3 хувиар биелсэн. Ариутгал халдваргүйжүүлэлт 725 м2 талбайд хийгдсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.15. Сумдын мал эмнэлэг үржлийн аж ахуйн нэгжүүдийн мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг нэмэгдүүлснээр мал эмнэлгийн стандарт хангалтыг дээшлүүлнэ.</p>	<p>Мал эмнэлэг ариун цэврийн тасгийг итгэмжлэлд оруулах бичиг баримтыг хүргүүлж, бэлтгэл ажлыг хангасан. Мах сүү зардаг захуудаас зохих дээж авч шинжилгээнд хамруулахаас гадна төслийн байгууллагуудтай хамтран ажиллаж дүн мэдээг гаргаж байна. 2008 онд мал эмнэлэг ариун цэврийн тасгийг итгэмжлэлд оруулж, хүнсний зах болон бусад сүү, мах хэрэглэж үйл ажиллагаа явуулдаг гуанз, ресторан, цайны газар, цэцэрлэг, сургууль зэрэг 120 гаруй байгууллагыг нууц кодоор коджуулж сар бүр ээлжээр дээж авч шинжилгээ хийж байна. МЭАЦ-ын тасгийг тохижуулж, иж бүрэн тоноглож, өндөр хүчин чадал бүхий багаж хэрэгсэлээр хангаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.16. Орон нутагт гарч буй оношлогдоогүй халдварт буюу эндемик өвчний судалгаа хийж оношлоно.</p>	<p>Халдварт өвчний 10 жилийн, паразит өвчний 5 жилийн судалгааг гаргаж, өвчний гаралт, дархалтын зураглалыг гаргаж GPS багажаар баталгаажуулах бэлтгэл хийв. Орон нутгийн чанартай орогномол өвчний гаргалтыг тогтоож шаардагдах эм хангамжийг хийгээд байна. Мал эмнэлгийн халдварт өвчний үйлчилгээнд жил бүр 19 нэр төрлийн вакцин, ийлдэс, лабораторийн шинжилгээнд 18 төрлийн оношлуур, урвалж ариутгал халдваргүйжүүлэлтэд 2 төрлийн 2.5 тн бодис, боловсруулалтанд 250-330 л туулгын бодисыг хэрэглэж байна. Мөн “Цагаан залаа” “ВИ. ТИ. И. НЕТ”, “СВС”, “Агро-Эх” ХХК-ууд болон бусад зах зээлээс 40-өөд нэр төрлийн эм бэлдмэлийг татан авч хэрэглэж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>2.8.17. Аймгийн төвд ХХААГ-ын харъяа мал эмнэлэг ариун цэврийн лабораторид вирусологийн тасаг байгуулж материаллаг</p>	<p>Асуудал боловсрогдож байгаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>

бааз тоног төхөөрөмжөөр хангана.	
2.8.18. Газар тариалан эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд зоорь барих ажлыг дэмжинэ.	Агропарк байгуулах зорилгоор 710 тн-ийн багтаамжтай 20 зоорь байгуулсан. <i>/Хэрэгжилт-50%/</i>
2.8.19. Монголын хөдөө аж ахуйн хөгжлийн шинэ загвар “Баянхонгор-Альянс” байгууллагын үйл ажиллагаанд аймгийн бүх сумыг хамруулна.	“Баянхонгор Альянс” дундын хоршоо нь Баян-Өндөр, Бууцагаан, Галуут, Богд сумдад салбартай, нийт 8 сумын 201 гишүүнтэй 28,3 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсон байна. Мерси Кор байгууллагын дэмжлэгтэйгээр өөрийн байртай болж, 2,5 сая төгрөгийн эд хөрөнгөтэй болж гишүүдийн бэлтгэсэн МAA-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд зуучлан борлуулах үүрэгтэй ажиллаж байна. Энэ онд үндэсний үйлдвэрлэгч “Гоёо”, “Эрдэнэт ноолуур” ХХК-уудад тэмээний ноос, сарлагын хөөвөр, ямааны ноолуурыг гэрээгээр бэлтгэж, гишүүдийнхээ урьдчилгаанд бэлнээр 13,0 сая, 29,4 сая төгрөгийн хүнсний барааг олгож, эргэн төлөлтөө хийж дуусаад байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
3.1.1. Байгаль хамгаалах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	Байгаль орчны мастер төлөвлөгөөг боловсруулан эхний хагас жилд багтаан батлуулахаар төлөвлөж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мастер төлөвлөгөө батлагдсаны дараа өөрийн аймгийн мастер төлөвлөгөөтэй уялдуулахаар хүлээгдэж байна <i>/Хэрэгжилт-10%/</i>
3.1.2. Гол, горхи булаг шандын эхийг хашиж хамгаалан орчныг тохижуулах ажлыг үргэлжлүүлж, 10 рашааны химийн найрлагыг тогтоож нэгдсэн бүртгэлд оруулан мэдээллийн сан бүрдүүлнэ.	Эрдэнэцогт, Заг, Галуут, Шинэжинст, Баянхонгор, Баацагаан, Баянбулаг сумдын нутаг дахь 11-н булгыг тохижуулах ажлын гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлээд байна. Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлагын сангаас Жаргалант, Гурванбулаг, Галуут, Жинст, Бууцагаан, Өлзийт, Баацагаан зэрэг сумдын 16 булгийн эхийг хамгаалах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийж гүйцэтгэгч нараар ажлыг хийлгэв. Санхүүгийн хямралын байдлаас шалтгаалан улсын төсвийн хөрөнгөөр Заг, Бөмбөгөр сумдад хөв байгуулах ажил хасагдсан болно. <i>/Хэрэгжилт-30%/</i>
3.1.3. Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших, гол,	2009 оны байдаар байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах 24 нөхөрлөлийг байгуулаад байна.

<p>мөрний ай сав газрын зөвлөл, нөхөрлөлд гэрээний дагуу хариуцуулж, нөхөрлөлийн гишүүдийг чадавхижуулах асуудлыг төрийн болон ТББ-тай хамтран хэрэгжүүлж, байгаль орчны төрийн хяналтыг сайжруулан байгалийн нөөц баялгийн халдашгүй байдлыг хангах үүрэг хариуцлагыг чангатгана.</p>	<p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>3.1.4. Баянхонгор сумын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, төв суурин газруудад хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлэх замаар орчны бохирдлыг бууруулна.</p>	<p>Баянхонгор сумын Засаг дарга, түүний Тамгын газар, УЦУОШАлба, бусад холбогдох байгууллагуудтай хамтран Баянхонгор сумын агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулав. Дэд хөтөлбөрийг Баянхонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн гарсан саналыг тусган 12 дугаар сард аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>3.1.5. Олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайг 100 хувь нөхөн сэргээж энэ талбайн тоо бүртгэл мэдээллийн сан, мэдээллийн ил тод байдлыг хангана.</p>	<p>Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн байдлыг аймгийн комисс газар дээр нь очиж шалган хүлээн авч байна. Одоогийн байдлаар Жамп ХХК Галуут суманд 0.5 га, Жаргалант суманд 9 га, Монголболгоргео ХХК 14.5 га, Ханшижир ХХК 8 га, Тулгажаргалант ХХК 5 га-д техникийн нөхөн сэргээлт хийснийг хүлээн авсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>3.1.6. Цианит, мөнгөн усны хорыг саармагжуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тавьж энэ ажлын үр дүнд 9-р сард Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтын дор Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу Онцгой байдлын ерөнхий газар саармагжуулах ажлыг хийв. Ажлын хэсэг саармагжуулах ажлыг 30 хоногт багтаан Баацагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Жинст, Баянлиг, Шинэжинст, Баяновоо зэрэг сумдын 28 цэгээс 2161 м<sup>3</sup> буюу 3252 тн шламыг цагаан цахирын хаягдлын даланд зөөж, бохирдсон газрыг саармагжуулах ажлыг зохион байгуулав.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>3.1.7. Үйлдвэрлэл үйлчилгээний газруудын байгаль орчинд нөлөөлөх байдлын</p>	<p>Эрдэнэцогт, Заг, Галуут, Шинэжинст, Баянхонгор, Баацагаан, Баянбулаг сумдын нутаг дахь 11-н булгыг тохижуулах ажлын гүйцэтгэгч нартай</p>

<p>үнэлгээний хэрэгжилтэнд тавих хяналтыг дээшлүүлнэ.</p>	<p>гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлээд байна. Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлагын сангаас Жаргалант, Гурванбулаг, Галуут, Жинст, Бууцагаан, Өлзийт, Баацагаан зэрэг сумдын 16 булгийн эхийг хамгаалах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийж гүйцэтгэгч нараар ажлыг хийлгэв.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>3.1.8. Нутгийн ард иргэд, малчид болон хувиараа ашигт малтмал олборлогч нарт экологийн боловсрол олгож, нөхөрлөл, бүлгийн хэлбэрт оруулан төсөл хөтөлбөрт хамруулна.</p>	<p>Төслийн багтай хамтран Бичил уурхай эрхлэгчдийн анхдугаар зөвлөлгөөнийг Жаргалант, Бөмбөгөр суманд зохион байгуулав. "Баянбөмбөгөр", "Байдрагийн хөгжил" ТББ-ын Бүх гишүүдийн хурлыг зохион байгуулав. ТББ-ын төлөвлөлт, удирдлага, үнэлгээний сургалт хийгдэв. Жаргалант сумын ХАМО-гч иргэдийн нийгэм, эдийн засгийн судалгааны анхны хувилбарыг төслийн багтай хамтран боловсруулав. Жаргалант, Бөмбөгөр сумдын ХАМО нарт зориулсан сургалтыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр өргөн сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Төрийн бус байгууллагуудын сургалт мэдээллийн төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хөдөлгөөнт мэдээллийн самбар, ном товхимол, гарын авлага материалаар хангалаа. "Өрхийн аж ахуйн хөгжил төв" ТББ-тай хамтран ХАМО иргэдэд сургалт зохион байгуулж гарын авлага материалаар хангалаа. Дээрх сургалтын үр дүнд Жаргалант сумын ХАМО иргэд 1.5 га Бөмбөгөр сумын ХАМО иргэд 3 га газар техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагтаа хүлээлгэн өгөв.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>3.1.9. Цөлжилтийг сааруулах, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор зориудаар хур тундас оруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>2009 оны 04 сарын 13-ны өдрөөс 04 сарын 23-ны өдрүүдэд УЦУОШГазрын "Хурын шим" төвийн мэргэжилтнүүдийн зохион байгуулсан сургалтанд УЦУОШАлбаны холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедици ажиллуулах эрх олгууллаа. Цаг агаарт зориудаар нөлөөлөх хээрийн экспедицийг 3 удаа зохион байгуулж ажиллан хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явууллаа.</p> <p style="text-align: right;">/ Хэрэгжилт 30%/</p>
<p>3.1.10. Улсын тусгай хамгаалалттай газар</p>	<p>Их богдын тусгай хамгаалалттай газрын захиргаа аймагт үйл ажиллагаа</p>



3.2.4. Аймаг, сумын газрын мэдээллийн санг улсын мэдээллийн сангийн сүлжээтэй холбох арга хэмжээ авна.	“TOPSURVEI “ ХХК-наар кадастрын зураглал ба бүртгэлийн ажлыг хийлгэсэн бөгөөд материалаа хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна. /Хэрэгжилт-30%/
3.2.5. МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэн бүрт гэр бүлийнх нь хэрэгцээнд газар өмчлүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулна.	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 97 иргэний материалыг хянан үзэж Аймгийн Засаг даргын 2009 оны эхний хагас жилд 5 захирамжаар гэр бүлийн 1 гишүүнд нь шилжүүлэн өглөө.Мөн аймгийн Засаг даргын 8 захирамжаар 474 иргэнд 60.1 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд нь өмчлүүлсэн. /Хэрэгжилт-30%/
4.1.1 Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг цаг үетэй нь нийцүүлэн байнга шинэчилж, төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь суралцах боломж нөхцлийг бүрдүүлэх, мэргэжил мэргэшлээ дээшлүүлэхэд нь зориулж сургалтын хөтөлбөр боловсруулж, ажлын байрыг бүртгэгдсэн нөөцтэй болгох замаар мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлнэ.	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, албад, сумдын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний багаас албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх, ажлын байранд тавигдах шаардлагыг өндөржүүлэх үүрэг өгч хяналт тавин ажиллаж байна. /Хэрэгжилт-30%/
4.1.2. Төрийн байгууллага бүрийн дотоод дэг журмыг сайжруулж, үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох, ажлаа тогтмол тайлагнах замаар төрийн албан хаагчдын хариуцлагын тогтолцоог сайжруулж, төрийн байгууллага, албан хаагчдаас төрийн албаны стандартыг хэлбэрэлтгүй сахиж мөрддөг болгоно.	Сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт Төрийн албаны стандарт” сэдвээр 4 цагийн сургалтыг зохион байгуулж ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж мөрдөн ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгөв. /Хэрэгжилт-30%/
4.1.3. Төрийн бодлого шийдвэрийг сурталчлах, үр дүнг тооцох, мэдээлэх, хяналт шинжилгээ хийх ажлын арга хэлбэр, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, үр дүнг дээшлүүлнэ.	Төрийн бодлого шийдвэрийг сурталчлах заалтыг сумдын Засаг дарга, хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарын гэрээнд тусгаж ажиллаж байна. Хяналт шинжилгээ хийх арга хэлбэрийг сайжруулах зорилгоор Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ-үнэлгээ хийх журам боловсруулан хэрэгжүүлж байна. /Хэрэгжилт-30%/

<p>4.1.4. Аймаг, сум, байгууллага, салбарын түвшинд төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, тэдний гэр бүлийг дэмжих замаар эрүүл мэнд, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн хэмжээнд хөдөө сумдын 15 эмч, аймгийн 1 эмч, 25 төрийн албан хаагчийг орон сууцаар хангаад байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>4.1.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын халаалт, Баян-Өндөр, Хүрээмарал, Галуут сумдын Засаг даргын тамгын газрын байрны өнөөгийн байдалд судалгаа хийж, хөрөнгийн асуудлыг жил жилийн төсөвт тусгаж шийдвэрлэх замаар шат дараатай хэрэгжүүлнэ. Төрийн байгууллагуудыг техник хэрэгсэл, компьютерээр хангана. Төрийн байгууллагуудын ажлын байрыг цайны газар, чийрэгжүүлэлтийн танхимтай болгох асуудлыг шийдвэрлэнэ.</p>	<p>Галуут сумын Засаг даргын Тамгын газрыг байртай болгох асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж 2010 оны төсөвт суулгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын халаалтын засварыг 2010 оны төсөвт суулгуулсан. МСҮТөвийн гадна талбайд нийтийн биеийн тамирын стандартын талбай, жижиг цэнгэлдэх хүрээлэн, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний “Бат-Идэр” ХХКомпанитай хамтарч ажилчдын сагсан бөмбөгийн гадна талбай, Эрдэнэмандал ахлах сургуулийн гадна талбай, ОБХэлтсийн дэргэд сагсан бөмбөг, гар бөмбөгийн задгай талбайг шинээр барьж байгуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>4.1.6. Гар аргаар алт олборлогчдод үзүүлэх төрийн хөдөлгөөнт үйлчилгээг бий болгоно.</p>	<p>Төслийн багтай хамтран “Бичил уурхай эрхлэгчид”-ийн анхдугаар зөвлөлгөөнийг Жаргалант, Бөмбөгөр суманд зохион байгуулж “Баянбөмбөгөр”, “Байдрагийн хөгжил” ТББ-ын бүх гишүүдийн хурлыг зохион байгуулав. Жаргалант сумын ХАМО-гч иргэдийн нийгэм, эдийн засгийн судалгааны анхны хувилбарыг төслийн багтай хамтран боловсруулав. Төрийн бус байгууллагуудын сургалт мэдээллийн төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хөдөлгөөнт мэдээллийн самбар, ном товхимол, гарын авлага материалаар хангасан. “Өрхийн аж ахуйн хөгжил төв” ТББ-тай хамтран ХАМО иргэдэд сургалт зохион байгуулж гарын авлага материалаар хангасны үр дүнд Жаргалант сумын ХАМО иргэд 1.5 га, Бөмбөгөр сумын ХАМО иргэд 3 га газар техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>4.1.7. Аймаг дахь төрийн архивыг дохиоллын систем бүхий зориулалтын тусгай байртай болгох, байгууллагуудын албан хэрэг</p>	<p>Төрийн архивын байрны зураг төсөл хийгдсэн байгаа. Хууль зүйн хэлтсийн Архивын тасаг нь Архивын ерөнхий газраас бүртгэл хайлтын программыг авч ашиглаж эхлээд байна.</p>

хөтлөлтийг бүртгэлийн нэгдсэн программд шилжүүлэх, төрийн архивын сан хөмрөгийн 20-иос доошгүй хувийг хайлтын программд шилжүүлэх.	/Хэрэгжилт-50%/
4.1.8. Төрийн үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ авдаг журам тогтоож, иргэдээс санал хүсэлт хүлээн авдаг цэгүүдийг бий болгоно.	Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор иргэдээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн сэтгэл ханамжийн судалгааг эрх бүхий судалгааны байгууллагаар авахаар заасны дагуу авсан. /Хэрэгжилт-30%/
4.1.9. Цагдаагийн хэлтэс, ШШГА, ОБХ зэрэг байгууллагуудыг үйл ажиллагааны онцлогт нь тохируулж тусгай тоногосон автомашинаар хангана.	Цагдаагийн хэлтэс нь 2009 оны 07 дугаар сарын 01-ээс холбооны хэрэгслээр төхөөрөмжлөгдсөн хөдөлгөөнт эргүүлийн 3 автомашиныг Баянхонгор сумын хэмжээнд ажиллуулж байгаа ба ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шатахууны асуудлыг нь тухай бүр шийдвэрлүүлэн ажиллаж байна. Замын цагдаагийн тасагт УАЗ-469, Онцгой байдлын хэлтэс ЗИЛ-131 машинаар парк шинэчлэл хийсэн. /Хэрэгжилт-30%/
4.1.10. Хууль хяналтын байгууллагуудыг төрийн мэдлийн орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.	Баянхонгор сумын 1 дүгээр багийн орон сууцны хорооллын нутаг дэвсгэрт аймгийн шүүхэд-7, прокурорын байгууллагад нэг, цагдаагийн хэлтэст 4, нийт 14 төрийн мэдлийн орон сууц байна. /Хэрэгжилт-30%/
4.1.11. Сумдад кобон барих ажлыг ээлж дараагаар хэрэгжүүлж, цагдаагийн хэсэг байгуулах ажлыг өргөжүүлэхийн зэрэгцээ ажилтан нэг бүрийг хөдөлгөөнт холбоо, бусад хэрэгслээр хангаж, тэдэнд хүний эрхийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэхэд анхаарч ажиллана.	-2008 оны улсын төсвийн 45.0 сая/төг-ний хөрөнгө оруулалтаар Богд суманд “Цагдаагийн кобон” бариулж 2009 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс ашиглалтад орууллаа. 2009 онд Баянцагаан суманд кобон барих асуудал төсвийн тодотголоор хасагдсан юм. -Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Богд суманд Цагдаагийн хэсэг байгуулах, Жаргалант сумын Цагдаагийн хэсгийг тасаг болгон өргөтгөх тухай” 2009 оны 99 дүгээр тогтоолыг гаргуулан, холбогдох тооцоо судалгаа, танилцуулгын хамт ЦЕГ-т хүргүүлсэн ба шийдвэрийг хүлээж байна. Цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг 2.0 сая/төг-ний өртөг бүхий 10 богино долгионы станц, 4 мотоцикль, 3 дижиталь камер, 2 зөөврийн, нэг иж бүрэн компьютерээр тус тус хангалаа. Мөн Цагдаагийн хэлтэст сэтгэл засал, алжаал тайлах танхимыг 6.1 сая/төг-ийн тоног төхөөрөмж, бусад хэрэгцээт зүйлээр тохижуулан байгууллаа.

	/Хэрэгжилт-30%/
4.1.12. Криминалистикийн шинжилгээний лабораторитой болгоно.	Одоогоор аймгийн Засаг даргаас иж бүрэн 1 компьютерээр шүүхийн шинжилгээний албыг хангаад байна.  /Хэрэгжилт-10%/
4.1.13. ШШГА-ны урьдчилан хорих байрыг хянах камертай болгож, шийдвэр гүйцэтгэлийн журмаар хураагдсан машин техник, эд зүйлийг хадгалах, худалдан борлуулах зориулалтаар граж, дэлгүүрийн барилгын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.	ШШГ Албаны урьдчилан хорих байрыг 5 камер бүхий хяналтын тоног төхөөрөмжтэй болгосон. Шийдвэр гүйцэтгэлийн журмаар хураагдсан машин техник, эд зүйлийг хадгалах, худалдан борлуулах зориулалтаар гараж, дэлгүүрийн барилга барих хөрөнгийн асуудал 2009 төсвийн тодотголоор хасагдсан ба 2010 оны төсөвт тусгагдаагүй болно.  /Хэрэгжилт-30%/
4.1.14. Хууль тогтоомж сурталчлах, эрх зүйн сургалт явуулахад шаардагдах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил жилийн төлөвлөгөөнд тусгаж байна.	2009 оны эрх зүйн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд зориулан 1,0 сая төгрөгийг төсөвт суулгуулж иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэж хүргэх, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хууль тогтоомж сурталчлахад зарцуулан ажиллалаа.  /Хэрэгжилт-30%/
4.1.15. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт сургалтын төв байгуулж байнгын ажиллагаатай болгоно.	-2009 онд иргэдэд хууль, эрх зүй, гэр бүлийн харилцаатай холбоотой болон бусад асуудлаар зөвлөгөө , мэдээлэл лавлагаа өгөх, эрх зүйн албан бус сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий төвүүдийг бүх сумдад байгуулсан ба төвүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж эхэлсэн.  /Хэрэгжилт-30%/
4.1.16. Сум, баг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, удирдлагын үйл ажиллагааг сайжруулан хууль тогтоомжийн иж бүрэн сан, цахим сантай болгоно.	Монгол улсын Засгийн газраас баталсан Жишиг сум баг шалгаруулах болзол журамд үндэслэн аймгийн “Жишиг сум, баг шалгаруулах “ журам боловсруулан батлуулж хэрэгжүүлж байна.  /Хэрэгжилт-30%/
4.1.17. Авлигатай тэмцэх зорилгоор төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг ил тод болгож, бүх нийтэд хийх сургалтыг өргөжүүлнэ.	-Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлж байна. -2009 онд авлигатай тэмцэх, ХОМ-ийг хэрхэн гаргах талаар сумдын удирдлагууд, албан байгууллагуудын дарга, эрхлэгч нар болон 300 гаруй иргэдэд нийт 4 удаа сургалт хийн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 2-3 төрлийн сурталчилгааны материал түгээн ажиллалаа.

	/Хэрэгжилт-30%/
4.1.18. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг бүлэг холбоо, ажлын баг ажиллуулах замаар квадратын системээр зохион байгуулж хэрэгжүүлнэ.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Баянхонгор сумын хэмжээнд квадратын системээр зохион байгуулах асуудлыг аймгийн ГХУСА33-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, улмаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулсан. Тэргүүлэгчдийн хурлаас асуудлыг шийдвэрлэснээр 07 дугаар сарын 01-ний өдрөөс 3 хөдөлгөөнт эргүүлийг Баянхонгор хотын хэмжээнд ажиллуулж байна.  /Хэрэгжилт-30%/
4.1.19. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний талаар иргэд, олон нийтэд сургалт, мэдээлэл хийж тэдний хандлагыг өөрчлөх замаар согтууруулах ундааны зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд онцгой анхаарна.	-Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих ажлыг бүх шатанд эрчимжүүлэх зорилгоор “Жишиг сум” болох болзлыг аймгийн Засаг даргын 2009 оны 111 дүгээр захирамжаар батламжлуулан бүх сумдад хүргүүлсэн ба сумууд “Жишиг сум” болох ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. -Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих тухай” Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрөөр 12 байгууллагын нийт 480 хүнд сургалт хийж, “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих тухай” Үндэсний хөтөлбөрөөс иргэдийн нийтлэг мэдвэл зохих асуудлуудаар материал бэлтгэн “Өнөөгийн Баянхонгор” сонинд нийтлүүлсэн. Мөн 10 сумын 1000 гаруй малчдад дээрх Үндэсний хөтөлбөр болон архидан согтуурахтай тэмцэх талаар аймгийн Засаг даргын гаргасан шийдвэрүүдийг танилцуулж яриа хийсэн.  /Хэрэгжилт-30%/
4.1.20. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг жил жилийн орон нутгийн төсөвт тусгаж байна.	-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” дэд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргын 2009 оны 241, 348 дугаар захирамжаар батламжлуулан сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна  /Хэрэгжилт-30%/
4.1.21. Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааг телевиз, хэвлэл мэдээллийн	-“Хүний эрхийн өдөр”, “Монгол Улсын иргэний Үндсэн эрх” -Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай болон Төрийн хяналт

бусад хэрэгслээр иргэдэд сурталчлах ажлыг өргөжүүлнэ.	шалгалтын тухай хууль, “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих тухай” Үндэсний хөтөлбөрөөр цуврал материал бэлтгэж, орон нутгийн “Өнөөгийн Баянхонгор”, “Цэнхэр дэлхий” сонинууд болон Тамгын газрын мэдээллийн самбар, Баянхонгор-TV”, “Хонгор-TV”, “Хөгжлийн ертөнц TV-10”-аар нийтэлж ажиллаж байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
4.1.22. “Нээлттэй хяналт-эрүүл Баянхонгор” төслийг аймагт хэрэгжүүлэх /Мэргэжлийн хяналтын газар /	“Нээлттэй хяналт, эрүүл Баянхонгор” төслийг 2009 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. “Нээлттэй хяналт, Эрүүл Баянхонгор төсөл”-ийн хүрээнд нийтдээ “Баянхонгор” телевиз, “Өнөөгийн Баянхонгор” сонины 13 дугаарт 17 гаруй мэдээ сурвалжлагыг нийтлүүлж, “Хонгор”, “Баянхонгор” телевизээр 11 удаагийн тусгай сурвалжлага бэлтгэж нэвтрүүлсэн. <i>/Хэрэгжилт-50%/</i>
4.1.23. Мэргэжлийн хяналтын газрын лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлж сүүлийн үеийн дэвшилтэт техник тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ.	2007-2008 онд шинээр спектрофотометр, рН-метр, аналитик жин, сахарын рефректометр, Eliza-уншигч, нимгэн үет хроматограф, центрифуг, сэгсрэгч, чийг хэмжигч, ламинар бокс, Зейтцийн аппарат, дижитал микроскоп, анаэроустат зэрэг хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг авч шинжилгээнд хэрэглэж байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
4.1.24. Аймаг, сумдын засаг даргын Тамгын газруудын барилга байгууламжийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж шат дараатай засварлах ажлыг шийдвэрлэнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын халаалтын шугамын их засвар, Галуут сумын ЗДТГазрын барилгын хөрөнгийн асуудлыг 2010 оны төсөвт тусгуулах арга хэмжээ авсан. Аймгийн сумдын ЗДТГазрын барилгын судалгааг гаргав. <i>/Хэрэгжилт-30%/</i>
4.1.25. Аймгийн Засаг даргын Тамгын газраас Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын жагсаалт гаргаж төр, иргэний нийгмийн түншлэлийг бий болгоно.	ХЭҮТ-ийн салбар, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны салбар зөвлөл, Авилгатай тэмцэх төрийн бус байгууллагуудтай аймгийн Засаг дарга гэрээ байгуулан ажиллаж байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
<b>4.2. Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлого.</b>	
4.2.1. Орон нутгийн цэргийн сургалтын төв байгуулна.	Орон нутгийн цэргийн сургалтын төв байгуулах, цэргийн штабын офицеруудыг хувийн зэвсгээр хангах тухай албан бичгийг Батлан

	хамгаалах яаманд, орон нутгийн цэргийг зэвсэг техникээр хангах тооцоог Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлсэн. <i>/Хэрэгжилт-30%/</i>
4.2.2. Цэргийн штабын террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг сайжруулж, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд татан оролцуулна.	Сумдын Засаг даргын Тамгын дарга нартай 2009 оны 1 дүгээр сард “Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл” сэдвээр 1 өдрийн мэргэжил арга зүйн сургалт явуулсан. - Баянхонгор аймгийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч Батлан хамгаалахын сайд нарын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлэн 20 бэлтгэл офицертой 2009 оны 3 дугаар сарын 23 – наас 4 дүгээр сарын 03 – ны өдрүүдэд “ <b>Жижиг салбаруудын байлдааны ажиллагаа</b> ” сэдэвт бэлтгэл офицеруудын давтан сургалтыг зохион байгуулан явуулсан. - 2009 оны 3 дугаар сард явагдсан “Галуут сумыг мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын чиглэлээр жишиг сум болгохтой холбогдсон сургалт, зөвлөгөөн” – д бэлтгэл офицеруудыг оролцуулсан. - Галуут сумын багийн дарга, байгууллагын дарга нартай “Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд багийн Засаг дарга, байгууллагын дарга эрхлэгч нарын үүрэг” сэдвээр 2009 оны 4 дүгээр сарын 3- ны өдөр 2 цагийн сургалт явуулсан. - <b>6 дугаар сард нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдтэй цэргийн мэргэжил олгох сургалтыг танкын наводчик, артиллерийн хол хэмжигч, артиллерийн тагнуулчин мэргэжлээр цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулан явуулаа.</b> <i>/Хэрэгжилт-30%/</i>
4.2.3. Гал унтраах болон аврах ажлын тоног зэвсэглэмжийг шинэчлэнэ.	Онцгой байдлын хэлтсийн гал унтраах болон аврах ажлын тоног зэвсэглэмжийг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан засварлаж галын 2 машинд ээлжийн засвар, усны машинд насос тавьсан. <i>/Хэрэгжилт-30%/</i>
4.2.4. Цаг уурын станцын тоог шаардлагатай хэмжээнд нэмэгдүүлэх, хур тундасны	Баянцагаан сумын хөдөө аж ахуйн харуулыг цаг уурын станц болгож өргөтгөсөн.

хэмжлийг бүх багт хийх боломжийг бүрдүүлнэ.	/Хэрэгжилт-30%/
4.2.5. Байгаль цаг уурын гамшгийн аюулыг бууруулах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх хүн хүч, техникийн нөөцийг бий болгож, гамшгаас хамгаалах нөөцийн санг хүрэлцээтэй болгоно.	- Аймгийн 20 сум, мэргэжлийн 7 алба, 4 тусгай зориулалтын мэргэжлийн ангийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг татан авч хянан баталгаажуулж, ХХААЖДҮГазар, Баянцагаан сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, сургууль дадлагаар баталгаажуулав.  /Хэрэгжилт-30%/
4.2.6. Онцгой байдлын хэлтэст мэдээлэл хүлээн авах станц суурилуулж, автомат дохиолол бүхий газруудтай шууд холбогддог болгоно.	Станц суурилуулах ажил хийгдсэн.  /Хэрэгжилт-30%/
4.2.7. Компьютер болон холбооны сүлжээний тусламжтайгаар гамшгийн тухай мэдээллийг холбогдох албан тушаалтнуудад нэгэн зэрэг очдог байх боломжийг бүрдүүлнэ.	Компьютер болон холбооны сүлжээгээр мэдээлэл шуурхай хүргэх асуудлыг судлаж байна.  /Хэрэгжилт-10%/
4.3.1.Иргэний бүртгэлийн төгөлдөржилтийг хэрэгжүүлж иргэний үнэмлэхийг ухаалаг үнэмлэхэд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж иргэний биеийн өгөгдлийг авах журам боловсруулна.	Бэлтгэл ажил бүрэн хангагдсан.  /Хэрэгжилт-30%/
4.3.2.Иргэний бүртгэлийн архивыг цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж галын аюулаас сэргийлэх дохиоллын системд холбоно.	Тооллогын хүрээнд тоологдсон эд хөрөнгө /газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө/-ийг эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, бүртгэгдээгүй үл хөдлөх эд хөрөнгө болон өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байгаа газрын хэмжээ, тоог сум, аймгийн хэмжээнд оршин байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны зориулалттай барилга байгууламжийн бүртгэлийг сум сумаар нь гаргаж мэдээллийн санг үүсгэлээ.  Мэдээллийн цахим санд эрхийн улсын бүртгэлд бүртгэгдэн баталгаажсан газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг оруулсан.

	/Хэрэгжилт-30%/
4.3.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн албаны бүртгэл мэдээллийн ажлыг цахим хэлбэрт шилжүүлнэ.	- Урьдчилсан байдлаар тоологдсон Баянхонгор сумын төвд оршин байгаа нийтийн зориулалттай орон сууцны мэдээллийг цахим санд оруулан дууссан.  /Хэрэгжилт-30%/
<b>Аялал жуулчлал</b>	
5.1.1. Байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газар, ховордсон амьтан, эмийн болон ховор ургамал бүхий газрыг улс, аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг өргөжүүлнэ.	Аймгийн түүх соёлын болон байгалийн үзэсгэлэнт газар, ховордсон ан амьтан, эмийн ургамал бүхий газруудын судалгааг холбогдох сумдуудаас авч мэдээллийн сан бүрдүүлж, аялал жуулчлалын веб сайтанд байрлуулаад байна. Галуут сумын Баянхонгор уулыг аймгийн тахилагат уул болголоо.  /Хэрэгжилт-10%/
5.1.2. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд тодорхойлсон “Амралт аялал жуулчлалын гурван бүс цогцолбор”, Баянговь сумын “Говь” цогцолбор, Шаргалжуутын халуун рашааны “Шаргалжуут” цогцолбор, түүх соёлын дурсгалт газар болох Заг-Байдрагийн “Хүрэн бэлчир” цогцолборуудыг байгуулах, шилдэг зураг төсөл шалгаруулах тендер зарлаж, шалгарсан зураг төслийн дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.	Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатны ажлын график гаргаж 2009 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган ажилласан. Баянхонгор аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулахаар ажлын комисс гарган ажиллаж дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулсан.  /Хэрэгжилт-30%/
5.1.3. Баянхонгор хотод байгуулах “Амралт аялал жуулчлалын гурван бүс цогцолбор”-ийн “Динозаврын парк”, Эрдэнэмандал хайрханы “Хүндэтгэлийн цогцолбор”-ийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, Хүүхдийн паркийн доторх бүтээн байгуулалтын ажлын зарим хэсгийг барьж ашиглалтад оруулна.	Динозаврын барималын ажил 95 хувьтай байгаа бөгөөд 2009 онд нэмж 7 ш жижиг махчин Динозаврын баримлыг байрлуулсан. Ламын гэгээний ойтой холбогдуулан Эрдэнэмандал хайрханы өвөрт Ламын гэгээний сэрэг дүрийг цул цагаан гантиг чулуугаар бүтээж хийв. Динозаврын паркт 500 модны нүх ухаж, талбайн хогийг зайлуулсан.  /Хэрэгжилт-30%/
5.1.4. Малчдын орлогыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, экологийн аялал	Аймгийн аялал жуулчлалын маршрутанд орсон газруудад нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын нөхөрлөл байгуулах бодлогыг

<p>жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	<p>хэрэгжүүлж эхлээд байна.  /Хэрэгжилт-10%/</p>
<p>5.1.5. Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.</p>	<p>2009 оны 12 сарын 04-06 хооронд болох “Mongolia ITF- 2009” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн” Мишээл экспо” Баянхонгор аймгийн аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, компани, иргэн, аж ахуйн нэгжүүдийн захирал, удирдах хүмүүстэй нь уулзаж энэ арга хэмжээнд өргөнөөр оролцсон.  /Хэрэгжилт-30%/</p>
<p>5.1.6. Монголын говийг үзэх гэж Өмнөговьд ирдэг жуулчны урсгалыг Баянхонгор руу татах зорилгоор Баянговь сумын Цагаан булагийн орчинд онгоцны буудал байгуулах асуудлыг холбогдох газруудад тавих.</p>	<p>     /Хэрэгжилт-0%/</p>
<p>5.1.7. Баянхонгорын аялалын маршрутыг аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа хангайн бүсийн аймгуудын аялалын маршруттай холбох бодлогыг хэрэгжүүлнэ.</p>	<p>Өвөрхангай аймгийн Хархорумд болсон Аялал жуулчлалын байгууллагуудын “Удирдах ажилтнуудын зөвлөлгөөн”-д аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын удирдах хүмүүстэй уулзаж хамтран ажиллах талаар мэдээлэл солилцож аймагтай хил зэргэлдээ оршдог Өвөрхангай, Архангай, Өмнөговь зэрэг аймгуудын Засаг даргын тамгын газар, БОАЖГазруудад тухайн аймгийн аялал жуулчлалын гурван чиглэлийн маршрутыг танилцуулж хамтран ажиллах асуудлыг, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд аймгийн аялал жуулчлалын маршрутыг хүргүүлж улсын аялал жуулчлалын сүлжээнд холбогдох саналаа албан ёсоор тавиад байна.  /Хэрэгжилт-30%/</p>
<p>5.2.1. Бүгд Найрамдах Солонгос Улсад төвтэй Зүүн хойд Азийн засаг захиргааны холбоодын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зүүн хойд азийн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.</p>	<p>- Зүүн хойт Азийн засаг захиргааны холбооны 2009 оны 9 сард Хятад улсын Шандунь мужид зохион байгуулсан бизнесийн уулзалтад аймгаас 3 төлөөлөгч оролцлоо. Солонгос улсад аймгаас 13 төлөөлөгч айлчилж "Жижиг дунд үйлдвэрийн холбоо"-той хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан.  /Хэрэгжилт-30%/</p>

<p>5.2.2. Хөрш зэргэлдээ болон хамтын ажиллагаатай улс орнууд руу хийх туршлага судлах бизнес аялалыг өргөжүүлж малчид, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг өргөнөөр оролцуулна.</p>	<p>БНХАУ-ын Хайнон мужид болсон Аялал жуулчлалын уулзалт зөвлөлгөөнд аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, бүтээгдэхүүн үзмэрүүдийн талаарх мэдээлэлүүдийг хүргүүлж сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>5.2.3. Өмнөд Солонгос, Польш, Болгар, Вьетнам, Хятад, ОХУ, Япон зэрэг улсуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэх хамтын ажиллагааны шинэ боломжийг идэвхтэй эрэлхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Болгар улсын элчин сайдын яаманд хамтын ажиллагааг сэргээх тухай албан тоот явуулсан ба уулзалтыг 7 сард зохион байгуулахаар төлөвлөсөн ч элчин сайдын саналаар хойшлуулсан</li> <li>- Австри улсад суугаа монголын төлөөлөгчидтэй холбоо барьж аймагт хог боловсруулах үйлдвэр барих санаа дамжуулаад байна.</li> <li>- БНХАУ-ын ӨМӨЗОрны Альша аймгийн Эзний хошуунд аймгаас 10 төлөөлөгч айлчилж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зураад цаашид хамтран ажиллах аймгийн ажлын хэсгийг томилоод байна.</li> <li>- Японы Ойта мужтай харилцаагаа өргөжүүлж Соого Сейко сургуулийн өргөтгөлийн хөрөнгийн 50,0 долларын асуудлыг шийдвэрлүүлээд байна.</li> </ul> <p>Хятад улсын Хэнан мужаас 8-9 сарын үеэр аялал жуулчлалын дэд хорооны анхдугаар хурлыг зохион байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан аялал жуулчлалын мэдээлэл материалыг цуглуулан гарын авлага хийж хурлын үеэр гишүүн байгууллагуудад тараах гэж байгаа тул энэ хүсэлтийн дагуу аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал болон аялал жуулчлалын бүтээгдэхүүн үзмэрүүдээр хийсэн мэдээ мэдээлэл, брошур зэргийг бэлдэж хүргүүлээ.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>5.2.4. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хоёр талын бизнес уулзалтуудыг өргөжүүлнэ.</p>	<p>2009 онд аймгаас бизнесийн болон төрийн байгууллагын төлөөлөгчдийг ОХУ-ын Кабанскийн район, Өвөрмонголын Альша аймаг, Солонгос улсын “Жижиг дунд үйлдвэрийн холбоодтой бизнесийн уулзалтуудыг зохион байгуулж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-30%/</p>
<p>5.2.5. ОХУ-ын Бурят Улсын Кабанскийн районтэй холбоо харилцаагаа өргөжүүлнэ.</p>	<p>Оросын холбооны улсын Кабанскийн районд аймгаас төлөөлөгчид айлчлаад ирсэн. Айлчлалын үр дүнд 2 орны хамтын ажиллагааны</p>

	санамж бичигт гарын үсэг зураад байна. Хамтын ажиллагааны гэрээгээр манай аймагт хамтарсан үйлдвэр байгуулахаар тохиролцсон. /Хэрэгжилт-30%/
--	---

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ